



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 6 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6 - 37

1.	Байнгын хорооны тогтоолын төсөл /Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт, шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	8
2.	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	8 - 23
3.	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 20 гишүүн 2023.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	23 - 34
4.	“Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын хуулийн 1995 оны 26 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн 2021.05.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	34 - 37

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 6 дугаар сарын 28-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 27 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: Г.Ганболд, Г.Дамдинням;
Эмнэлгийн чөлөөтэй: Б.Бейсен, Ц.Цэрэнпунцаг.*

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор үг хэлж, хэлэлцэх асуудлын дарааллын гуравт орсон Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын эхэнд хэлэлцэхийг, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн “Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын хуулийн 1995 оны 26 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын дараалалд нэмж оруулах гэсэн горимын санал гаргав. /10.28/

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	3
Бүгд:	11

72.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт, шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 0
Бүгд: 11
100 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Мал эмнэлгийн бодлогын асуудал эрхэлсэн ахлах шинжээч Х.Алтангэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Ж.Батжаргал, Ц.Туваан, Т.Аубакир нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Т.Энхтүвшин, Н.Ганибал, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Ж.Бат-Эрдэнэ: Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 20 гишүүн 2023.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монгол Улсын зөвлөх мал зүйч, хөдөө аж ахуйн бодлого судлаач, доктор Б.Эрдэнэбаатар, Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал ахуй, биотехнологийн сургуулийн захирал, доктор Д.Гүрбазар, Хөгжлийн бодлого судлаач, Монгол Улсын зөвлөх мал зүйч, доктор Г.Сувдаа, Бэлчээр ашиглагчдын холбооны Бэлчээрийн ургамал судлаач, доктор Д.Булгамаа, Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, доктор М.Сувд, Хөдөө аж ахуйн эдийн засагч, доктор Ц.Энх-Амгалан, Бэлчээрийн экологи судлаач, магистр У.Будбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Р.Болормаа, Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Н.Ганибал, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Бэлчээр ашиглагчдын холбооны Бэлчээрийн ургамал судлаач, доктор Д.Булгамаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын хуулийн 1995 оны 26 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн 2021.05.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Р.Болормаа, Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Г.Мөнхцэцэг үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасны дагуу тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 4

Бүгд: 14

71.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 33 минут үргэлжилж, 19 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр 12 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.САРАНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
10 цаг 27 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ж.Бат-Эрдэнэ: Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны энэ өдрийн хуралдааны ирцийг танилцуулъя. Ирсэн гишүүдийг танилцуулъя.

Тилеуханы Аубакир гишүүн ирсэн, Жадамбын Бат-Эрдэнэ ирсэн, Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн, Хаянгаагийн Болорчулуун гишүүн ирсэн, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн, Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн ирсэн, Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн, Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн ирсэн, Ганзоригийн Тэмүүлэн гишүүн ирсэн, Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн, Төмөртоогогийн Энхтүвшин гишүүн ирсэн.

Ингээд ирц 57.9 хувь болсон тул өнөөдрийн хуралдааныг эхэлье.

Ингээд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаан эхэлж байна. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал 3 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээр асуудал. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр

нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. Хэлэлцэх эсэх.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ж.Батжаргал нарын 29 гишүүн 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдөр мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Байнгын хорооны тогтоолын төсөл. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх хяналт шалгалт хийх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах тухай гэсэн ийм гурван асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой асуух асуулт байна уу? Гишүүдээс. Хоёр гишүүн. Д.Өнөрболор гишүүн, Г.Тэмүүлэн гишүүн нэрээ өгөөрэй.

Тэнд Г.Тэмүүлэн гишүүнээр тасалъя Д.Өнөрболор гишүүний микрофоныг өгье.

Д.Өнөрболор: Дарга аа, гурав дахь асуудалд нь хэлэлцэж байгаа тогтоолын төслийг нэгдүгээр асуудал болгоод баталчхаж болдог болов уу?

Дараа нь, нэг ажлын хэсэг давхардаад байгаа юм. Миний.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгвэл санал хураах байх. Тийм үү?

Дараалал өөрчлөх учир. Тийм. Ер нь дараалал өөрчилж болно шүү дээ. Тийм ээ. Дараалал өөрчилчихье. Тэгье

тэгье. Нэгдүгээр асуудлаар аваад хэлэлцчихье. Тэгье.

Г.Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүдийн өдрийн мэндийг хүргэе.

Хэлэлцэх асуудал дээр нэг горимын санал гаргах гэсэн юм. Би хэлэлцэх асуудал нэмэх гэсэн юм.

“Улсын тусгай хамгаалалт газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай” гээд Улсын Их Хурлын 1995 оны тогтоол байгаа. 1995 оны 26 дугаар тогтоол байгаа.

Тэгээд тогтоол дээр нэмэлт, өөрчлөлт оруулах энэ асуудлыг хэлэлцэх асуудлын дараалалд оруулах гэсэн юм.

2021 онд өргөн барьсан. Хууль хэлэлцэх эсэхийг нь 2021 ондоо хийсэн. Тэгээд хаврын чуулган дуусахаас өмнө энэ асуудлыг нэг эцэслээд хэлэлцээд дуусгах шаардлагатай байна.

Энэ асуудал дээр хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулж өгөөч ээ л гэсэн санал гаргаж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Даргын зөвлөлийн хурлаар орсон юм уу?

Г.Тэмүүлэн: Даргын зөвлөл дээр ороогүй. Тэгэхдээ горимын саналаар дэгийнхээ хуулиараа Байнгын хорооны гишүүд горимын санал гаргаж хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах эрхтэй.

Байнгын хороо болоод Улсын Их Хурлын чуулган дээр.

Ж.Бат-Эрдэнэ: Бэлтгэгдсэн материал байгаа юу?

Г.Тэмүүлэн: Бэлэн. Энэ чинь нөгөө хэлэлцэх эсэхээ шийдчихсэн.

Тэгэхээр ямар нэгэн өөрчлөлт орохгүйгээр шууд хэлэлцэгдээд явах бүрэн боломжтой асуудал байгаа.

Тогтоолын төсөл дээр нэмэлт, өөрчлөлт оруулах л асуудал байгаа. Өргөн баригдсанаараа л явна гэсэн үг. Тэр дээр нэг их өөрчлөлт орох асуудал байхгүй.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ дээр горимын санал оруулсан юм чинь санал хураачих уу?

Тэгвэл Г.Тэмүүлэн гишүүний оруулсан саналаар. Хуулийн төсөл юу гэж байгаа билээ? Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Г.Тэмүүлэн гишүүний. Бүтэн нэрээр нь хэл дээ.

“Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай” 1995 оны 26 дугаар тогтоолд нэмэгдэл оруулах тухай гэсэн асуудлыг хэлэлцэх тухай санал хураалт. Санал хураалт. /алх цохив/

72.7 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд дөрвөн асуудал хэлэлцэхээр боллоо. Ж.Батжаргал гишүүн дэмжсэн шүү. Протоколд оруулаарай.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт, шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Тогтоолын төслийг танилцуулъя.
Та бүхэнд.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны тогтоол.

Ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос **ТОГТООХ** нь:

1.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт, шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор;

Гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал; Н.Ганибал; Ц.Идэрбат; Ц.Туваан;

2.Ажлын хэсгийн үйл ажиллагаанд холбогдох яам, агентлаг, бусад байгууллагын албан тушаалтан, мэргэжлийн хүмүүсийг тухай бүрд татан оролцуулсугай.

3.Ажлын хэсгийн санал, дүгнэлт, шийдвэрийн төслийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд, шаардлагатай бол чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг ажлын хэсэг /Д.Өнөрболор/-т даалгасугай.

Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Саранчимэг гэсэн байна.

Тогтоолын төслийг дэмжье гэсэн нь санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

100 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Хоёр.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

/Засгийн газар 2023.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт

шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл.

Хэлэлцэх эсэх байгаа. Хууль санаачлагчийн танилцуулгыг Х.Болорчулуун сайд. Х.Болорчулуун сайдын микрофоныг өгье.

Х.Болорчулуун: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2022 оны 04 дүгээр тогтоолоор Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд заасан Мал эмнэлгийн байгууллага мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Мөн уг тогтоолоор Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэгтэй байгууллагуудын жагсаалтад Мал эмнэлгийн албыг нэмж оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан байдаг.

Түүнчлэн “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын 2 дахь заалтын 4 дэх дэд заалтад өндөр ашиг шимт малын үр хөврөлийг гадаад улсаас нэгдсэн бодлогоор авах, үржил, селекцийн ажилд био техникийн ололтыг нэвтрүүлэх, малын удмын санг хамгаалах, мал үржүүлэг, технологийн ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан.

Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах талаар салбарын хяналтын нэгдсэн тогтолцоо бүрдээгүйгээс мал,

амьтны гоц халдварт өвчний тархалт, гаралт нэмэгдэх, малын генетик нөөцийг ашиглах тусгай зөвшөөрөл олгоход тавих тусгайлсан нөхцөл, шаардлага тодорхой бус байгаагаас малыг өөрийн дур зоргоор ашиглаж, үүний улмаас малын үүлдэрлэг байдал, тэсвэрт чанар алдагдах, бие давжаарах, ашиг хүчин буурах нөхцөл байдал үүсээд байна.

Иймд эдгээр асуудлыг шийдвэрлэх Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дээрх тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор мал аж ахуйн салбарын харилцааг зохицуулж байгаа Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Малын генетик нөөцийн тухай, Амьтан, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслүүдийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засгийн дараах үр дүн гарна.

Хууль тогтоомж үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон бусад бодлогын баримт бичигт тусгагдсан хүнсний аюулгүй байдлыг хангах, мал, амьтны эрүүл мэнд, малын удмын сан хамгаалах, баталгаажуулах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох талаарх зорилтууд хэрэгжих бүрэн боломж бүрдэнэ.

Мал эмнэлгийн хяналтын нэгдсэн тогтолцоо бий болж, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд тавигдах худалдааны түнш орнуудын шаардлагыг хангах нөхцөл бүрдэнэ.

Төрийн байгууллагуудын давхардуулан гэрчилгээ олгодог хүнд суртал үгүй болж бизнес эрхлэх таатай орчин бүрдэж иргэдийн эрхийн баталгаа сайжирна.

Дээрх хуулийн төслүүдийг хэлэлцэн дэмжиж өгнө үү.

Ж.Бат-Эрдэнэ: Х.Болорчулуун сайдад баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Х.Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Ц.Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Э.Цолмонжаргал мөн яамны Хуулийн хэлтсийн дарга, Х.Алтангэрэл мөн яамны Мал эмнэлгийн бодлогын асуудал эрхэлсэн ахлах шинжээч нар ирсэн байна.

Танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Г.Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа.

Т.Энхтүвшин гишүүний микрофоныг өгье.

Т.Энхтүвшин: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг уншиж үзлээ.

Тэгээд хуучин мэргэжлийн хяналтад байсан Хилийн мэргэжлийн хяналтын алба гэж байсан. Гаалийн байгууллага руу шилжсэн. Хуучин яах вэ дээ, мал, амьтны эрүүл мэндийн бичгийг юу гэдэг юм хилээр гарахад нь хилийн, мэргэжлийн хяналтын байгууллага зөвшөөрөл өгдөг байсан юм шүү дээ.

Одоо ч гэсэн юу гэдэг юм, энэ хилийн мэргэжлийн хяналтын

байгууллага бол Гаалийн ерөнхий газарт бас яг энэ салбараараа, энэ чиг үүргээрээ шилжээд очсон байж байгаа.

Тэгээд энэ дээр үзэж байхад нэг ийм үг, үсэг орсон байна л даа.

Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл мэнд, ариун цэврийн баталгаа болж буй гэрчилгээг гаалийн байгууллага олгож байгаа нь олон улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журамд нийцэхгүй байна гэдэг ийм юуг тайлбар дээр нь оруулж ирсэн байна.

Тэгээд энэ яагаад нийцэхгүй байгаа юм бэ? Ямар олон улсын дүрэм, журам зөрчөөд байгаа юм.

Хуучин мэргэжлийн хяналтын газар, хил хилийн мэргэжлийн хяналтын байгууллага байхдаа олгоод явж байсан юм гааль дээр очихоор яагаад болдоггүй юм.

Энэ ямар олон улсын конвенц, олон улсын гэрээ, норм нормативыг зөрчөөд байгаа юм?

Тэр хилийн мэргэжлийн хяналтын хүмүүс чинь ихэвчлэн ургамал, хорио цээр болон малын их эмч нар л байдаг шүү дээ.

Тэгээд энэ тал дээр нэг тайлбар хэлээд өгөөч ээ. Энэ тал дээр.

Заавал Хүнс, хөдөө аж ахуйн яаманд очсон мэргэжлийн хяналтын хөдөө аж ахуйн байцаагч дээр өгөх гээд байгаа юм уу? Энэ дээр нэг тайлбар хэлж өгөөч ээ л гэж хүсэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Х.Болорчулуун сайд хариулах уу? Х.Болорчулуун сайдын микрофоныг өгье.

Х.Болорчулуун: Мэргэжлийн хяналтын байгууллага гэдэг том хяналтын байгууллага татан буугдаж яам яаман дээр салбарын хяналт дээрээ очсон.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаман дээр ч гэсэн мал, амьтны, хүнсний бүх л хяналтын үүрэг хариуцлага ирсэн.

Өмнө нь мал, махыг экспортод гаргахад маш олон давхардал байсан. 6 байгууллагаас бүр 10 гаруй хоног, 13, 14 хоног хөөцөлдөж байж экспортын зөвшөөрөл авдаг ийм хүнд сурталтай байсан.

Үүнийг цахим болгож байгаа. Нэг цонхны бодлогоор хүнд сурталгүй үйлчлэх ийм бодлого хэрэгжиж байгаа.

Ер нь экспортод гаргах юман дээр бид элдэв олон улсад мөрддөггүй цаас, бичиг баримт шаардаад байх ямар ч шаардлагагүй.

Мэргэжлийн хяналтын байгууллага байхдаа салаад хилийн мэргэжлийн хяналт гээд гааль руугаа оччихсон байсан. Тэнд яг одоогоор гааль дээрээ бас нэг дайвар маягтай ажиллаад байгаа юм.

Ялангуяа тэр нэг **“ногоон бичиг”** гээд хамгийн сүүлд хилээр гарахад хилийн мэргэжлийн хяналт нэг бичиг өгдөг байсан. Тэр ямар ч шаардлагагүй гэж үзэж байгаа юм.

Хөдөө аж ахуйн яам мал эмнэлэг дээрээ үндсэн цахимд нэг цонхны бодлогоор орж экспортод мал, ургамлын түүхий эд экспортод гарах бүрэн боломжтой.

Ж.Бат-Эрдэнэ: Тодруулах уу?
Т.Энхтүвшин гишүүн.

Т.Энхтүвшин: Яах вэ ойлгож байна. Тэгэхдээ нэг юмыг та хэд их сайн ойлгоорой.

Энэ хойд хөрштэй ч тэр, урд хөрштэй ч тэр ер нь гаалийн байгууллага л гэрээ хэлэлцээр хийгээд л явдаг тийм л олон жилийн туршлага байж байгаа шүү дээ.

Тэгээд нөгөө хилийн мэргэжлийн хяналтын олгож байсан юу гэдэг юм зөвшөөрлийг өгөхөө больчихоор нөгөө хойд хөрш маань, урд хөрш маань юу гэдэг юм мал, амьтны гаралтай түүхий эдийг чинь авахгүй болчих вий. Үүнийгээ та хэд судалж үзсэн юм уу?

Хил хоорондын уулзалт гээд л явахаар ер нь үндсэндээ гаалийн байгууллага л ахлаад явдаг шүү дээ. Тухайлбал, мах, махан бүтээгдэхүүн гаргах ажлын хэсэг ирлээ гэхэд гаалийн байгууллага л ирдэг. Урд хөршөөс ч тэр, хойд хөршөөс ч тэр.

Тэгэхээр энэ эрх зүйн орчныг нь ингээд өөрчилчихдөг. Дараа нь юу гэдэг юм нөгөө бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад хүндрэл учруулах, нөгөө гадна, дотнын хилийн байгууллагууд хүлээж авахгүй байх эрсдэл үүсчих юм биш биз дээ?

Хилийн мэргэжлийн хяналтын байгууллага.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Х.Болорчулуун гишүүн хариулья.

Х.Болорчулуун: Урд, хойд хөршийн нийгмийн байгууламжийг мэдэж байгаа.

Хойд хөрш мэргэжлийн хяналт давамгайлсан байгууллагатай.

Урд хөрш яг өөрийн чинь хэлдгээр ийм бүтэцтэй.

Бид малын экспорт, импортыг зөвхөн хоёр хөршдөө биш булангийн орон, Казахстан, Узбекистан гээд олон оронд гаргаж байгаа.

Олон улсын ер нь нийтлэг жишиг нь бидний энэ оруулж байгаа, энэ хуулийн төслийг өргөн барьж байгаа ийм байдлаар байдаг юм гэдгийг л хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Ж.Батжаргал гишүүний микрофоныг өгье. Ж.Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа.

Тэгэхээр Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл өргөн баригдаж орж ирсэн байгаа юм.

Тэгээд энэ хууль өөрөө их онцлогтой, үнэхээрийн л чухал хууль байгаа л даа.

Бид бүхэн Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах асуудал, ер нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалт, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ гэвэл энэ хуулийн хэрэгжилтийг хангах ажил, түүнд тавих хяналтыг л эрс сайжруулах тухай л асуудал байгаа юм.

Одоо орж ирчхээд байгаа зүйл дээр хоёр, гурван зүйл тодруулах зайлшгүй шаардлага байна уу гэж хараад байгаа.

Нэгдүгээрт, хамгаалалттай аж ахуй гэдгээ худалдаа, тэгээд үндсэндээ мал, амьтны янз бүрийн өвчнөөс хамгаалагдсан тэр аж ахуйнхаа тухай асуудал яриад байгаа юм уу гэж харагдаад байгаа.

Үүнийг томьёолоод байгаа томьёоллын утга учир нь юундаа байна вэ гэдэг нэг ийм асуудал байгаа.

Хоёр дахь асуудал. Тандалт гэдэг юм байгаа. Энэ уг нь тоон мэдээлэл, баримт дээр дүн шинжилгээ хийдэг асуудал мөн юм уу даа гэдэг асуудал байна л даа.

Ер нь энэ чинь яг нарийндаа нүдэн баримжааны үзлэгийн тухай буюу ерөнхий шинж тэмдгийн илэрцийн тухай асуудал дээр нь байх юм биш үү. Энэ тандалт чинь.

Юу гэж ойлгоод үзээд байна вэ гэж.

Дараагийн асуудал нь, онош батлагдахаас өмнө нийтэд мэдээлэх ёстой юу, мэдээлэхгүй байх ёстой юу гэдэг асуудал.

Энд орж ирчхээд байгаа зүйлээрээ “нуун дарагдуулбал” гэдэг үг орчхоод байгаа учраас онош батлагдаагүй байхад мэдээлэх тухай, нийгмийг түгшээх тухай ойлголт яваад байх шиг санагдаад байгаа.

Тэгэхээр үүнийг зөв зохицуулахгүй бол байж магадгүй гэсэн тэр сууриа гэдэг юм уу, тэр юмаа тодорхой дэглэм, хязгаарлалтдаа аваад нийтэд нэг их учиргүй мэдээлэл түгээчихгүй, оношоо батлагдахаар мэдээлдэг энэ зарчим руугаа явахгүй бол болохгүй юм биш үү. Үүнийг юу гэж томьёолоод байна гэж.

Дараагийн нэг асуудал. Энэ мал эмнэлгийн эмийн сан, эм, био бэлдмэлийн худалдан борлуулалт, тэр мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний борлуулалтын асуудлыг мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангаагүй байранд гээд байгаа юм.

Тэгээд тэр “**мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага**” гэдэг энэ үгэн дотор тэр бүх стандартууд багтаж чадаж байгаа юу?

Өнөө “**хүйтэн хэлхээ**”-ний гэдэг юм уу, янз бүрийн тусгайлсан шалгуур, шаардлага тавигддаг юмнууд чинь байгаа юу гэж.

Үүнийг юу гэж харж томьёолж энд оруулаад ирэв гэдэг асуудал байна.

Нэг ийм хэдэн зүйл дээр тодорхой хариултаудыг авъя.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Х.Болорчулуун сайд.

Х.Болорчулуун: Бид олон улсын жишгээр мал, махаа экспортод үнэ цэнтэй гаргая гэвэл “**эрүүл бүс**” байгуулж байж гаргах, “**хамгаалалттай аж ахуй**” байгуулж байж гаргах асуудал л даа.

Өнөөдөр урд хөрштэйгөө тэр “**дулааны арга**”-аар боловсруулж гаргаж байгаа байдал зөвхөн хоёр улсын хоорондын л гэрээний асуудал. Өөр улс оронд хэрэгждэггүй л дээ.

Тэгэхээр “**хамгаалалттай аж ахуй**” гэж “**эрүүл бүс**”-ийг бага хэмжээний газар дээр оршин тогтнодог.

“**Хамгаалалттай аж ахуй**” гэж олон улсын худалдааг дэмжих болон улс, бүсэд тархсан өвчнөөс хамгаалах, тэмцэх зорилгоор тандалт, био аюулгүй байдал, хяналтын арга хэмжээ авах, био хамгаалалт дийн нийтлэг дэглэм, журмыг хэрэгжүүлэх замаар бусад мал, амьтнаас тусгаарлан маллаж байгаа эрүүл мал, амьтан бүхий байгууламжийг “**хамгаалалтын аж ахуй**” гэж хэлж байгаа юм.

Хоёрдугаарт, тэр “**тандалт**” гэж мал, амьтны эрүүл мэндтэй холбоотой тоон мэдээлэл, баримтыг төлөвлөгөөтэйгөөр цуглуулан нэгтгэж дүн шинжилгээ хийх, үр дүнг тухай бүрд нь мэдээлэх, шаардагдах арга хэмжээ авах нөхцөл боломжийг бүрдүүлэх цогц үйл ажиллагааг “**тандалт**” гэж томьёолж байгаа юм.

Гуравт нь, тэр онош батлагдахаас өмнө мэдээлэх ёстой юу, үгүй юу.

Ер нь онош батлагдаагүй байхад мэдээж болохгүй нь ойлгомжтой. Аливаа өвчнийг.

Тэр онош батлагдмагц мал эмнэлгийн ерөнхий эмч л орон даяар зарладаг хууль, журамтай гэдгийг бас хэлье.

Түүхий эдийн борлуулалтын шаардлага, экспорт, импортын шаардлага тэр стандартыг л мэдээж баримталж байж экспорт, импорт явуулна л даа. Тэр шаардлагыг хангаж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ж.Батжаргал гишүүн болсон уу? Тодруулах уу?

Ж.Батжаргал гишүүн тодруулья.

Ж.Батжаргал: Тийм.

Ер нь манай хөдөө аж ахуйн салбар, дан дамаа мал аж ахуйн салбар дээр “**тайван бүс**”-ийн тухай асуудал нэлээн яригддаг.

Энэ нь үндсэндээ “**халдварт өвчингүй бүс**”-ийн тухай асуудал.

Энэ талбайн хэмжээ өөрөө нэмэгдэх тухай яригддаг.

Дээр нь мэдээж мах экспортолдог гэдэг юм уу, нийтийн хэрэглээнд

нийлүүлдэг аж ахуйн байгууллагууд мах бэлтгэлийнхээ асуудлыг ёстой тэр хамгаалагдсан бүсийнхээ түвшинд хийх эрх зүйн зохицуулалтыг нь их тодорхой болгож өгөх ёстой юм.

Тэгээд тэгж яг харагдаж чадаж байгаа юм уу, үгүй юм уу, энэ чинь. Би тэр мах бэлтгэж байгаа аж ахуйн байгууллагууд чинь тэр тайван бүсээсээ мал, махаа бэлтгээд, тэгээд тодорхой тэр бүс дээрээ суурилан маллаад үйлдвэр лүүгээ орж ирэхдээ тэр хяналтын тодорхой цаг хугацаануудаа дамжаад гардаг энэ юм нь үүгээрээ тодорхой харагдаж байгаа юу гэж.

Хоёр дахь эндээс тодруулмаар байгаа нэг зүйл бол бид дархлаажуулалтын асуудал ярьж байгаа юм. Одоо үнэхээрийн өвчин нэлээн бүс нутгийг өргөн хүрээтэй.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ж.Батжаргал гишүүний микрофоныг сунгая. 1 минут.

Ж.Батжаргал: Тэгэхээр энэ дархлаажуулалтын асуудлыг бид ер нь урьд өмнө нь тэгж хараагүй юм билээ.

Одоо ер нь тэгж харах ёстой юу гэж би бодоод байгаа.

Тодорхой бүс нутгуудаар нь тэр технологийн цаг хугацаанд нь эрэмбэлж хийх тухай асуудал. Ингэж байж хүнснийхээ хангамжийн аюулгүй байдал, хангалтын хомсдолгүй байлгах үүднээс нь хийх ёстой зүйл биш үү гэж.

Бүгдийг нь нэг зэрэг эхлүүлчихээр зэрэг өнөө хийгдсэн дархлаажуулалтын био бэлдмэл, малын биеэс гадагшлах цаг хугацаа гэдэгтээ захирагдаад нэг хэсэг тодорхой хугацаанд нийлүүлэлт тал дээр сөрөг нөлөө үзүүлэх юм биш үү.

Тийм учраас эрэмбэтэйгээр, одоо юу гэдэг юм 5 сарын эхний 10 хоногт энэ бүс нутагтаа, 5 сарын 20-ноос 30-ны хооронд энэ бүс нутагтаа гэж явж байж нийлүүлэлтийнхээ хангалтын асуудлыг бас давхар бодож барих ёстой юм биш үү гэсэн нэг ийм тодруулах зүйл байх юм. Энэ нь ямар юу байна?

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг хариулья. Хэдэн номер вэ? 3 уу, хэд вэ? 5 номерын микрофон.

Ц.Болорчулуун: Ж.Батжаргал гишүүний асуултад нэмэлт хариулт өгье.

Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун.

“Хамгаалагдсан аж ахуй” дээр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гаргаж байгаа зөвлөмжийн хүрээнд нэгдүгээрт, стратеги төлөвлөгөөг боловсруулах ёстой.

Энэ ажил дээр бид манай дээр явж байгаа Азийн хөгжлийн банкны төсөлтэй хамтраад энэ стратеги төлөвлөгөөг боловсруулаад ерөнхийдөө дууссан байгаа.

Энэ төлөвлөгөөн дээрээ хэрхэн яаж хамгаалалттай аж ахуй цаашид ажиллах вэ гэдэг зүйлээ нарийвчилж тусгаад ингээд явах учиртай.

Үүнийг боловсруулаад, холбогдох олон улсын экспертүүд ирээд энэ дээр ажиллаад, Монголын нөхцөлд таарсан стратеги төлөвлөгөөг боловсруулаад дуусаж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ц.Туваан гишүүн асуулт асууя.

Ц.Туваан: Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж ирж байгаа юм.

Энэ хуулийг ер нь хамгийн сүүлд нэлээн тийм том амбицтайгаар салбарын хувьд баталсан.

Өөрөөр хэлбэл дэлхий дээр байгаа Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын мөрддөг дүрэм, журмын дагуу мал эмнэлгийн байгууллагыг босоо тогтолцоотой болгосон.

Тэгээд эндээс үр дүн гарсан уу гэвэл гараагүй гэж үзэж байгаа.

Бүр сахил хүртээд шал дордов гэдэг шиг юм болсон.

Юу гэхээр Мал эмнэлгийн ерөнхий газар босоо тогтолцоотой болсон. Үүнтэй зэрэгцээд Монгол Улс малын гоц халдварт өвчиндөө ер нь баригдаж эхэлсэн.

Маш олон сумууд дээр олон төрлийн малын гоц халдварт өвчнүүд гарсан.

Тэгэхээр одоо энэ хууль дээр энэ асуудлаа нэгмөсөн өөрчлөлт оруулж ирж байгаа дээр нь жоохон өөрчлөлт хийхгүй бол болохгүй байна.

Үүнтэй холбоотой тэр босоо тогтолцоо гээд орсон. Тэр удирдлага нь ийм болсон ч гэсэн яг үүнийг чинь анхан шатад хийдэг сум дээр гэхэд мал эмнэлгийн алба бий болгож байгаа юм. Хоёр хүнтэй.

Нэг нь малын мал эмнэлгийн байцаагч гээд байцаагчийн эрхтэй нэг хүн байгаа. Нэлээн сумдад энэ байхгүй байгаа.

Хоёр дахь хүн нь тэр малын “эпидемиологич” гээд нэг хүн байгаа. “Тархвар судлаач” гээд.

Энэ хүн бол бүр байхгүйтэй адилхан. Дутагдалтай.

Тэгэхээр иймэрхүү яг хэрэгжүүлэх тал дээрээ асуудлаа яаж харж байгаа юм бэ? Үүнийгээ эндээ засах юм байна уу, үгүй юу? Нэгэнт хуулийн нэмэлт, өөрчлөлт одоо ороод ирж байгаа энэ боломжийг ашиглаад энэ дээр ямар ийм бодолтой байна?

Хоёрдугаарт нь, экспортын асуудал.

Одоо манай малчид хийх ажлаа хийчихсэн. Малчид ямар ажил хийсэн гэхээр энэ малыг чинь өсгөх хариулах, маллах ажлуудаа хийгээд байгаа.

Тэгэхээр эд нарын хийж чадахгүй нэг ажил байгаа юм. Тэр нь юу гэхээр мал аж ахуйн салбараас гарсан түүхий эд, бүтээгдэхүүн.

Энэ чинь мах, сүү, дотор, өлөн тийм ээ. Хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн. Арьс шир, ноос ноолуур. Үүнийг борлуулах.

Цааш нь аваачиж тэр экспортод гаргаж мөнгө олох ажлыг хийхгүй бол эргээд Монгол Улс өөрөө хот хөдөө гэлтгүй улс даяараа том эрсдэлд орж байна.

Ямар эрсдэл гэхээр бид байгалийн бүтэн цөлийн дунд амьдрах болчихлоо.

Энэ жил маш олон газар гандуу байна. Өвс ургах цагтаа ургасангүй. Энэ өвөл бол чанга өвөл болно шүү.

Одоо Булган, Сэлэнгэ, Хөвсгөл, Архангайг л эс тооцвол ер нь бусад газар ер нь гандуу байна.

Тэгэхээр энэ дээр юу яриад байгаа гэхээр бид экспортоо маш эрчимтэй

хурдацтайгаар нэмэгдүүлэх ийм бодлого барихгүй бол асуудал үүссэн.

Саяхан харин Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэд худалдааны асуудал эрхэлсэн агентлаг үүсэж байгаа юм билээ. Үүнтэй маш хурдан холбогдоод энэ малчдынхаа бүтээж өгсөн түүхий эдээ л экспортлох ажил дээрээ энэ хуулиудаа. Энэ хорио цээрийн хууль бас орж ирж байгаа юм байна.

Яагаад гэхээр малчид чинь яах юм бэ. Хөөрхий тэд нар чинь ямар ноосоо, ноолуураа үүрээд, махаа үүрээд Эрээн, Араб, Казахстан явж чадахгүйгээс хойш үүнийг хийх дэд бүтцийг нь төр хийж өг л дөө.

Энэ дээрээ салбарын яам ажилламаар байна. Арьс, ширийг нь жалгыг нь нэг хөдөө орон нутгаар үнэгүй хаягдаж байгаа энэ дээр нөгөө арьс ширний цогцолбор энэ тэрийнхээ юман дээр нэг сэтгэл гаргаад бас жоохон явуулмаар байна.

Төр нь хийх ёстой ажлаа хийхгүй. Тэгээд буруутгах болохоороо хэдэн малчдаа буруутгаад суугаад байна.

Тэгэхээр энэ дээр бид онцгой арга хэмжээ авахгүй бол манай бэлчээрийн одоо бүр 70 хувь гэдэг тоог чөлөөтэй хэлдэг боллоо. Энэ цөлжилт.

Ганц хөдөөгийнхний асуудал биш шүү. Хотын, Монгол Улсын асуудал болоод байна шүү.

Тэгэхээр энэ дээр экспортод гаргах гэдэг тал дээрээ, хорио цээр дээрээ ямар ахиц гарсан зүйл энэ хуульдаа оруулж ирж байгаа вэ гэсэн асуулт байна.

Ж.Бат-Эрдэнэ: Х.Болорчулуун гишүүн хариулья.

Х.Болорчулуун: Ц.Туваан гишүүн малын өвчин, ялангуяа гоц халдварт өвчин ихэссэнтэй холбоотой ярьж байна.

Энэ босоо тогтолцоотой болсондоо ихэссэн юм биш ээ.

Ер нь босоо тогтолцоотой байж энэ гоц халдварт өвчинтэй нэгдмэл стратегиар тэмцэнэ.

Малын гоц халдварт өвчин юунаас болж үүссэн бэ гэвэл нэгдүгээрт, бид харамч хүн хоёр төлнө гэгчээр малын тарилга, вакцины санхүүжилтийг үндсэндээ хасчихсан.

Одоо энэ 36 дугаар тогтоол батлагдаж байж хэдэн төгрөг жил жилдээ, 4 жилийн хугацаанд, 5 жилийн хугацаанд суухаар боллоо шүү дээ.

Түүнээс өмнө малын тэр вакцин, тарилгын мөнгийг хассан.

Хоёрдугаарт, үйлчилгээний хөлс хэт бага.

Нэг үхрийг тарихад 200 мянга байсан. Өнгөрсөн жил харин 400 мянга болсон. 400 төгрөг. Тийм. 400 төгрөг болсон.

Мянган үхэр тарихад 200 мянга мянгаар тарина гэхээр тэр чинь зөвхөн малын эмч очоод тарьчихгүй. Үхэр баригч байна, бензин тосны зардал байна.

Тэр юу үлдэх вэ. Хүнд юм үлддэггүй байсан байхгүй юу. Энэ 400 төгрөг ч бага.

Цаашдаа бүр мянган төгрөг хүрэх ёстой гэсэн ийм бодлого яам барьж Сангийн яамтай бас ярилцаж байгаа. Энэ талаар.

Энэ хоёр хүчин зүйлээс болж малын өвчин гол нь бид тавиад туусан юм. Үүнийгээ арилгахгүйгээр хөдөө сум, аймагт байгаа хувийн мал эмнэлэг хөгжих ямар ч боломжгүй байсан юм шүү гэдгийг бас хэлье.

Хоёрдугаарт, экспортын талаар ярьж байна.

Экспорт дээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бүх л төрөл дээр анхаарч байгаа.

Мал, махыг хөлөөр нь ч бай, түүхийгээр нь ч бай, дулааны аргаар ч бай ингээд гаргахыг чөлөөтэй гаргаж байгаа. Квотгүй болсон. Нэг цонхны бодлогоор үйл ажиллагаа эхлээд явагдаж байна.

Үүний үр дүнд өнгөрсөн жил 16-хан мянган тонн мах гарсан бол одоо энэ хагас жилийн байдлаар 40 мянган тоннд хүрч байна.

Махан дээр экспортын тооны хувьд нэмэлт гарч байна. Харин үнийн хувьд бид 3 доллар гаруй, 4 доллар орчмоор борлогдож байгаа нь бас тийм хангалттай үнэ гэж үзэхгүй байна.

Түрүүний хэлдгээр “хамгаалалттай аж ахуй”, “эрүүл бүс” байгуулж байж мал, махаа бусад улсын жишгээр үнэ цэнтэй гаргах нөхцөл бүрдэнэ гэдгийг хэлэх байна.

Арьс, шир дээр мөн 2013 оноос эхлээд хаачихсан байсан. Арьс ширээ гадагшаа гаргахыг. Үүнийг үйлдвэр ашиглалтад ортол л гэсэн хугацаагаар Засгийн газрын тогтоолыг яам оруулж байж 2 жилийн хугацаатай чөлөөтэй бүх төрлийн арьс, шир гарахаар болсон гэдгийг хэлье. Гарч байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Т.Аубакир гишүүн асуулт асууя.

Т.Аубакир: Баярлалаа. Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Энэ оруулж ирж байгаа төсөл дээр зарим асуудлыг нь дэмжиж байгаа юм.

Би бас өөрөө гаалийн байгууллагад ажиллаж байсан. Үндсэндээ энэ дээр яах вэ, та бүхний оруулж ирж байгаагаар хоёр ойлголт яваад байна шүү дээ.

Нэг нь, экспортын гэрчилгээг гаалийн байгууллага өгдөг. Олон улсын тэр шаарддаг олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг Мал эмнэлгийн ерөнхий газар өгөөд байна. Тийм ээ.

Би үүний өмнө өнгөрсөн оны сүүлээр мал, махны экспортын ажлын хэсгийг ахалж ажилласан.

Энэ дээр бид нарын ажлын хэсгийн гол зорилго экспортыг дэмжих зорилготой, экспорт эрхэлдэг тэр аж ахуйн нэгжүүдэд хүндрэлгүй байх, түргэн шуурхай байх, давхардалгүй байх энэ тэр асуудлууд бас явж л байсан л даа.

Тийм учраас миний хувьд Мал эмнэлгийн ерөнхий газар нэг гэрчилгээ олгоод, дахиад Гаалийн ерөнхий газар дээр очихоор экспортын гэрчилгээ олгоод ингээд хүндрүүлээд баймааргүй байгаа юм.

Энэ бол Мал эмнэлгийн ерөнхий газар дээрээ хоёуланг нь өгөхийг, төвлөрүүлэх нь зөв гэж үзэж байгаа юм.

Яагаад гэвэл экспорт хийх гэж байгаа хүмүүс маань энэ түгжрээн дотор цаг хугацаа алдаад хоёр байгууллагаас хоёр ижил төрлийн шахуу бичиг авах гээд хоёр тийшээ явж байхаар Мал

эмнэлгийн ерөнхий газар дээрээ төвлөрүүлчих нь зөв.

Би сая Гаалийн ерөнхий газартай бас ярилаа. Хэдий тэнд хилийн мэргэжлийн хяналтынхан очсон ч гэсэн бас яг Хөдөө аж ахуйн яамны бүтцэд байгаа шиг яг мэргэжлийн тэр хяналтаа манай тал юу л бол гэж байгаа юм.

Тийм учраас хэдүүлээ экспортыг нэгэнт тууштай дэмжих ёстой. Энэ дээрээ үндэслээд **“экспортын гэрчилгээ”** гээч зүйлийг Мал эмнэлгийн ерөнхий газар дээрээ төвлөрүүлчих нь зөв. Ер нь бол.

Тийм учраас энэ асуудлыг дэмжиж байна.

Хоёрдугаарт, мал, махны экспортын ажлын хэсэг дээр бас нэг гаргасан гол шийдвэрүүдийн нэг танай дэд сайдаар ахалсан **“нэг цонхны үйлчилгээ”** маань юу болчхов оо?

5 сардаа бараг нээлтээ хийчихнэ. Экспорт эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд ерөөсөө Хөдөө аж ахуйн яаман дээр очоод л бүх тэр 7 байгууллагын 40 гаруй төрлийн бичиг баримтыг **“нэг цонхноос авна”** гэдэг шийдвэрийг гаргаад удахгүй нээлтээ хийнэ гэсэн. Энэ маань яагаад чимээгүй болчхов?

Сая Ц.Туваан гишүүн хэлж байна. Энэ жил зуншлага бас нэг их тийм айхтар сэтгэлд хүрээд байхаар байхгүй. Энэ өвөл бас мөн л экспортын асуудал гарч ирнэ.

Тийм учраас нэг цонхныхоо үйлчилгээг даруй нээгээч ээ.

Мал, махны экспортыг ахалж ажилласан ажлын хэсгийн Та бүхэнд өгсөн үндсэн чиглэлүүдийн нэг бол **“нэг цонхны үйлчилгээ”**-тэй болго гэсэн.

Тийм учраас экспортын гэрчилгээг танай дээр төвлөрүүлэхийг дэмжиж байна.

Хоёр дахь миний асуулт. Нэг цонхны үйлчилгээ яг юу болсон бэ? Хэзээ нээгдэх вэ гэдэг асуултад хариулт өгөөч? Тодруулна. Дараа нь.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Х.Болорчулуун гишүүн хариулъя.

Х.Болорчулуун: Т.Аубакир гишүүн яг зөв ярьж байна.

Үнэхээр **“мал эмнэлгийн олон улсын гэрчилгээ”**-г олон улсын жишгийн дагуу Мал эмнэлгийн ерөнхий газар өгдөг.

Гаалийн ногоон бичиг гээд **“экспортын гэрчилгээ”** гэж олгож байгаа. Энэ бол ямар ч хэрэггүй.

Нэг ёсны давхардсан ажил байсан. Үүнийг нэг болгож байгаа.

Ер нь цаашдаа мэргэжлийн хяналтаас салаад хилийн мэргэжлийн хяналт гээд оччихсон. Энэ бүтэц гаалийнхаа хажууд байх уу, ингээд дайвар маягтай байх уу, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам энэ мал эмнэлгийнхээ хажууд харьяанд ирэх үү гэдэг асуудал яригдах байх гэж хэлэх байна.

Бид ямар ч байсан дөнгөж 4 сараас салбарын хяналтын бүтэц, стратеги батлагдаад, ажлаа хийгээд явж байна.

Дотоод хяналт ажлаа ямар ч байсан жигдрүүлчхээд энэ дараачийн асуудлыг бас ярина гэсэн бодлогын чиглэлтэйгээр шийдвэрлэнэ гэсэн бодлоготой байгаа гэдгийг хэлье.

“Нэг цонхны бодлого” мал, мах экспортод гаргах нэг цонхны бодлого хэрэгжинэ.

Энэ хагас жилээ дуусаад 7 сарын 01-нээс албан ёсоор хэрэгжээд цахимжаад явах гэж байгаа гэдгийг хэлье. 7 сарын 01-нээс. Тийм. Дараачийн хагас жилээс. Тийм.

Ж.Бат-Эрдэнэ: Г.Мөнхцэцэг гишүүн алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн танилцуулгатай холбогдуулан санал хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгье.

Т.Аубакир, гишүүн, Т.Энхтүвшин гишүүн. Т.Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Т.Аубакир гишүүн саналаа хэлье.

Т.Аубакир: Х.Болорчулуун сайд аа, манай Хөдөө аж ахуйн яамныхан ч гэсэн.

Бид экспортыг тууштай дэмждэг байх ёстой.

80 сая орчим малтай гээд байгаа. Эдийн засгийн үр өгөөж нь нэгдүгээрт юу билээ.

Хоёрдугаарт, бэлчээр талхлалт, энэ цөлжилтөө та нар хар даа. Одоо баруун аймаг руу явахад, говийн аймгууд руу явахад 20 жилийн өмнө ийм байгаагүй шүү дээ.

Энэ цөлжилтийг дэмжиж байгаа, хөөрөгдөж байгаа гэх юм уу гол хүчин зүйлүүдийн нэг бэлчээрийн мал аж ахуй мөнөөс мөн.

Үүний зохицуулалт дээрээ бид анхаарах ёстой. Үүний зохицуулалтуудын нэг хэлбэр нь экспортоо тууштай дэмждэг байх ёстой.

Монгол Улс жилдээ доор хаяж 20-оос 30 сая малыг заавал экспортолдог байх ёстой.

Тийм учраас экспортын асуудал дээр бид ямар нэгэн хүндрэлгүй, түргэн шуурхай байх, хөрш улсууд руугаа экспорт, манайхаас мал, мах импортолдог улсуудтай харилцаа холбоогоо сайжруулах.

Үүний нэг хэлбэр нь Гааль, Мал эмнэлгийн ерөнхий газар хоёр дээр давхардалтай байсан бичиг баримтыг нэг болгох явдал зөв.

Тийм учраас экспортыг бид тууштай дэмждэг байх ёстой. Тэр “**нэг цонхны үйлчилгээ**”-гээ хурдан ажилд оруулаад, энэ экспорт хийж байгаа, одоо ирэх жилийн өвлийн бэлтгэл өдийд явчихсан байх ёстой.

Наадмын маргааш намар гэж. Одоо ингээд өвс тоосны асуудал. Тэгээд л мал, махны экспортын асуудал яригдана. Үүнийгээ угтуулж бид хийгдэх ёстой ажлуудаа хийх ёстой гэж.

Тийм учраас бэлчээр талхлалт энэ тэр юман дээр одоо Газрын тухай хууль ч гэсэн явж байгаа.

Ер нь та бүхэн одоо яг ингээд хөдөө орон нутгуудаар явж байгаа гишүүд байгаа байх. Үнэхээрийн цөлжилт гамшгийн түвшинд оччихлоо шүү дээ.

Тийм учраас үүнийг бас нэг багасгах, сааруулах нэг хүчин зүйл бол яах аргагүй мал, махны экспортыг дэмжих явдал гэж хэлмээр байгаа юм.

Тийм учраас Хөдөө аж ахуйн яамныхандаа бас энэ талаар захиж хэлье гэж.

Ж.Бат-Эрдэнэ: Т.Энхтүвшин гишүүн саналаа хэлье.

Т.Энхтүвших: Ерөнхийдөө дэмжиж байгаа, дэмжиж байгаа.

Тэгээд тэр гол асуудал бол бид энэ мал эмнэлгийн мэргэжлийн боловсон хүчнийг л сайн бэлтгэх тал дээр нэлээн анхаарах ёстой юм болов уу гэсэн бодолтой байж байна.

Ялангуяа говийн бүсүүд дээр цөлжилтийн асуудал, малын гоц халдварт өвчний асуудал маш их гарч байгаа.

Тэгээд юу гэж тайлбарладаг вэ гэхээр нөгөө зэрлэг ан амьтнаас дамжлаа л гэдэг ийм асуудал яригддаг.

Тийм учраас би юу хэлэх гээд байна гэхээр нэгдүгээр асуудал, та бүхэн одоо энэ сумдад ажиллах мал эмнэлгийн мэргэжилтнүүдээ сайн бэлдэх хэрэгтэй. Зөвхөн Дорноговь аймгийн нутаг дэвсгэрээр бодоход 14 суманд одоо бараг л 20 гаруй мал эмнэлгийн мэргэжилтэн дутуу байж байгаа юм.

Тэгээд ямар хөлс хангамжийг нь өгөх юм. Тэр говийн нэмэгдлийг нь өгдөггүй юм уу, ямар урамшуулал өгдөг юм.

Тийм учраас тэр боловсон хүчнийг хангах талаар та хэд нэг бодлого барьж ажиллаач ээ гэдэг ийм асуудал.

Хоёр дахь асуудал, яах аргагүй та түрүүн хэлсэн. Үнэхээр нэг вакцины мөнгө гээд тавьчихдаг. Тэгээд нөгөө вакцины мөнгө нь хаа ч хүрдэггүй. Бензин шатахуун. Тэгээд мэдээж

томилолтын зардал. Очоод хүн хүч ажиллана. Малыг нь барьж өгөхөөс эхлүүлээд маш их хэмжээний зардал гардаг. Тэгээд хөлс нь нэмэгддэггүй.

Тэгээд энэ хөлсний асуудлыг ч гэсэн энэ хууль дээр оруулаад тухайн жилийн инфляцын түвшинд байдаг юм уу, тухайн жил болгонд нь энэ хөлсийг тогтоодог ийм аргачлалыг хийж өгөхгүй бол энэ чинь ерөөсөө явахгүй байгаад байгаа юм.

Сумдад ажиллаж байгаа тэр хувийн мал эмнэлгүүд бүгд дампуураад дууссан. Яагаад гэхээр мөн ялгаа байхгүй энэ вакцины хөлс муутай. Ингээд л цаашид ажиллах бололцоо боломж байхгүй. Нөгөө боловсон хүчнээ бэлддэггүй. Дандаа л тэтгэвэрт гарсан, хуучин ажиллаж байсан тийм л малын эмч нар л үлдсэн байгаа шүү дээ.

Тийм учраас хөлсийг нэмэгдүүлэх асуудал дээр онцгой анхаарах хэрэгтэй байна. Энэ хөлсийг нэмж байж цаашдаа сум, орон нутагт мал эмнэлгийн хувийн эмнэлэг, мал эмнэлгийн тасаг амьд оршин тогтнох бололцоо боломж байгаа юм гэдгийг л хэлмээр байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Н.Ганибал гишүүн.

Н.Ганибал: Энэ хуулийг дэмжиж байна.

Ер нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Генетик нөөцийн тухай хууль салаад тусгай хууль болсноос хойш амьдрал зайлшгүй өөрчлөгдөх ёстой заалтуудыг оруулж ирсэн байна л даа.

Х.Болорчулуун сайд аа, хөдөө орон нутгаас сонгогдсон 52 гишүүн байгаа. Байнгын тойргоороо явж байгаа. Яг бодит амьдрал дээр байнгын нүүр

тулж байгаа гол асуудал бол бэлчээрийн асуудал гэдгийг бүгдээрээ мэдэж байгаа.

Одоо гишүүд санаачлаад хууль өргөн барьж байна. Хоёр хэсэг хуулийг өргөн барьсан.

Уг нь Засгийн газар энэ асуудлаа өөрсдөө бариад ингээд уг нь явмаар байх юм.

Тэгээд энэ асуудалдаа гүн рүү нь орохгүй. Үе үе бэлчээрийн асуудал ярихаар хулчийдаг ийм л улс төрч нар л бий болчихоод байгаа байхгүй юу.

Дараа нь яах юм. Малчдаас буруу зөрүү юм хийгээд том өөрчлөлтөөс айдаг.

Тэгэхдээ энэ нь айж болохгүй л дээ. Одоо хэдүүлээ ер нь энэ дээр маш сайн тооцоотой явахгүй бол дур дураараа асуудалд хандах нь өөрөө бас буруу.

Энэ чинь бүс нутаг болгон өөр өөр гэсэн зовлонтой. Өөр өөр асуудалтай.

Тэгэхээр үүнийг бүр цогцоор нь шийдэх ёстой. Ер нь Монгол Улсын хөдөө аж ахуйн өнөөдрийн бүтэц, үйл ажиллагаагаа явуулахад хүндрэл гараад байдаг асуудал нь хэдэн хүрээлэнгүүдээ аваачаад Боловсрол, шинжлэх ухааны яаманд аваачаад өгчихсөн.

Тэгээд энэ асуудал нь яг өнөөдөр Х.Болорчулуун сайд дээр ч гэсэн хүндрэл байгаа байх.

Яагаад гэхээр үржлийн асуудлууд, тэр бэлчээрийн асуудлуудыг мэргэжлийн шинжлэх ухааны түвшинд асуудлыг ярих гэхээр нөгөө гол шинжлэх ухаан нь салаад явчихсан.

Тэгээд үүнийгээ шинжлэх ухаан дээр суурилсан асуудлуудаа шийдье гэхээр яамны тодорхой юу гэдэг юм,

боловсон хүчин дээр тулгуурлаад хийнэ гэх нь өөрөө өрөөсгөл байгаа байхгүй юу.

Олон улсын практик ч гэсэн тийм. Энэ асуудлыг уг нь нэлээн явуулж байгаад тэгээд Боловсролын байнгын хороо, боловсролын сайд нар үүнийг өөрсөд дээрээ зүгээр нэг томилгооны асуудал, тэр хүрээлэнд нэг урсгал зардлын асуудлыг жил болгон төсөв дээр суулгаж өгдөг. Тэр эрдэм шинжилгээний санг бол яг тодорхой бодитой чухал асуудлуудыг авч хэлэлцдэггүй юм.

Энэ дээр Х.Болорчулуун сайд маань бас нэг бодолтой байгаа байх. Тийм ээ. Энэ бол угаасаа бид бүгдийн зовлон болчихоод байгаа юм.

Тэгээд цаашид ер нь асуудлуудыг ингээд газар газар дээр нь. Одоо хуульд өөрчлөлт оруулах уу? Тэр саад тотгоруудаа яаралтайгаар засаад засаад явах нь зөв л дөө. Тэгээд энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Би таван үг хэлээдэхье.

Ер нь Х.Болорчулуун гишүүн ээ, яамныхан. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах гээд.

Цаг үеэ олсон зөв хууль чинь орж ирж байна. Үүнийг сайшааж байгаа шүү.

Энэ дээр нэлээдгүй өөрчлөлтүүд орсон байх гэж ойлгож байгаа. Хэлэлцэх явцад өөрчлөлтүүд оруулах учраас санаа юмнуудаа оруулаад явах байх.

Ер нь хөдөө аж ахуйгаа нэлээн шинэчлэх тал дээр, бэлчээрийн мал аж

ахуйгаа хагас суурин руу оруулах тал руу ерөөсөө бодлого хараахан дутуу яваад байна гэж хараад байгаа юм. Х.Болорчулуун сайд аа.

Одоо та ч өөрөө мэдэж байгаа. Хөдөөгөөр явж байгаа. Саяын хавар айхтар хүнд хавар боллоо шүү дээ.

Тэгээд л ерөөсөө замын хажуугаар мал уначихсан, эсвэл унахаа ядчихсан, туйлдчихсан малтай аж ахуй харагдаж байна шүү дээ.

Мал аж ахуй гэдэг чинь ерөөсөө ингэж л харагдаад байна.

Ингэж явж байгаад тэр мал нь үхнэ үү, эсвэл унана уу, эсвэл боохой тэр хангай нь аваад явна уу гээд явдаг цаг чинь одоо хойно хаягдсан байх хэрэгтэй шүү дээ.

Бид чинь арай ондоо ямар нийгэмд ажиллаж амьдарч, ямар зуунд амьдарч байгаа билээ. Энэ чинь мал аж ахуйгаа нэлээн өндөр түвшинд нь босгох хэрэгтэй болчихоод байна шүү дээ.

Тэгээд үүнтэй холбоотой бэлчээрийн аж асуудлаа хэрхэн зохицуулах юм?

Тэгээд тэжээлийн асуудлууд. Үүнийгээ ямар түвшинд. Өндөр хөгжилтэй орнуудыг бид мэдэж байгаа. Тэр түвшинд нь дээш нь гаргаж ирэх юм гэсэн асуудлууд чинь байх юм.

Тэгээд гуравдугаарт яг үүнтэйгээ уялдуулаад таны түрүүний яриад байгаа тэр эрүүл бүс гэдгийг маш яаралтай оруулж ирээд батлуулаач ээ.

“Эрүүл бүс” гэдэг асуудлыг анхаарлын түвшинд гаргаад ирдэг чинь маш сайн байгаа.

Эрүүл бүсийг бий болгож байж, малын шилжилт хөдөлгөөнийг бид үгүй болгож байж, тэгээд мал эрүүл болж байж тэгж байж экспорт руу гарах том суурь чинь энэ байгаад байгаа шүү дээ.

Тийм болохоор үүнийгээ маш яаралтай оруулах хэрэгтэй байна. Малыг өвчинтэйгөө тэмцэх асуудал. Энэ дээр чинь нэлээн асуудлууд орж ирж байгаа байх. Хөдөө аж ахуйн яам энэ дээрээ нэлээн анхаараад ажиллаарай.

Тэгээд экспортыг нэмэгдүүлэх асуудал дээр түрүүн тэр гишүүн хаанаас. Ц.Туваан гишүүн хэлсэн байх аа. Энэ гадагшаа экспортолж байгаа аж ахуйн нэгжүүдээ ер нь нэлээн журам, цэгцэд оруулж байгаад. Бас нэгтгээд.

Ерөөсөө жилдээ төдий хэмжээний мал, мах гадагш нь гаргах, экспортод гарах боломж бололцоо байна гээд. Тэр бололцоо хэрэгцээгээ буцаад нийлүүлэлтгүйгээ уялдуулаад ямар ямар аймгаас, хилийн бүс байдаг юм уу, ямар ямар төв суурин газар энэ бүсчилсэн хөгжлийнх нь түвшинд ямар хэмжээнд малаа нийлүүлж гадагш нь гаргах ийм боломж бололцоо байгаа юм гэдэг дээрээ нэлээн төвлөрсөн тийм төлөвлөгөө оруулж ирээч ээ л гэсэн ийм хүсэлт байгаа шүү.

Ингээд гишүүд санал хэлж дууслаа.

Санал хураалт. Та танилцуулсан.

Ерөнхийдөө таныг ойлгож байгаа. Яагаад гэхээр зөв саналууд оруулж ирсэн. Хариулт чинь ч гишүүдтэйгээ санал нэг байгаа учир үүнийгээ чуулган дээр хамгаалаад, танилцуулаад явах байх гэж бодож байна.

Ингээд оруулж ирсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд дэмжье

гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал, дүгнэлтийг Т.Аубакир гишүүн Улсын Их Хурлын чуулганд танилцуулъя.

71.4 хувиар санал дэмжигдлээ.

Гурав.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 20 гишүүн 2023.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудал. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал танилцуулъя. Ж.Батжаргал гишүүний микрофоныг нээе.

Ж.Батжаргал: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын нэр бүхий гишүүд санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр танилцуулж байна.

Бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, сэргээх, сайжруулах чиглэлээр эрх зүйн зохих хүрээнд цаашид тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх хууль зүйн болон практикийн дараах үндэслэл шаардлага зайлшгүй тулгамдаж байна гэж үзэж энэхүү хуулийн төслийг боловсруулсан болно.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.5.2.2-т бэлчээр ашигласны төлбөр тогтоох, эзэмшүүлэх, хамгаалах болон нөхөн сэргээх, хариуцлага хүлээлгэх чиглэлээр

эрх зүйн орчныг бүрдүүлж, бэлчээрийн одоогийн төлөв байдал, цаашдын хандлагад суурилсан бэлчээрийн даацыг бүс нутаг бүрээр нь шинэчлэн тогтоож, малын тоо толгой, төрөл, сүргийн бүтцийн зохистой харьцааг хангана гэж “Алсын хараа-2050”-д Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 8.3.3-д бэлчээрийн газрыг ашиглах, сайжруулах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг тодорхой болгож, бэлчээрийн менежментийн нэгдсэн системийг бий болгож, бэлчээрийн доройтол цөлжилтийг бууруулна гэж, Монгол Улсын Засгийн газар газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.5-д бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, сайжруулалтын хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, бэлчээрийн доройтол, цөлжилтийг бууруулна гэж тус тус заасан.

Сүүлийн 20 гаруй жилийн туршид бэлчээрийг ашиглах, хамгаалахтай холбоотой эрх зүйн харилцааг сайжруулах шаардлагатай байгаа талаар янз бүрийн түвшинд олон удаа хэлэлцэж энэ дагуу хуулийн 4 төслийг боловсруулсан боловч өнөөг хүртэл шийдэлд хүрээгүй байна.

Эдүгээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Газрын тухай хуульд бэлчээрийг нийтээр, дундаа ашиглахаар зохицуулсан нь бэлчээрийг ямар ч хяналтгүй, даацыг

нь олон дахин хэтрүүлэн талхлагдал доройтолд оруулж, улмаар цөлжилт эрчимжихэд хүргэсэн байна.

Үүний төлөө хэн ч хариуцлага хүлээсэнгүй, хүлээхээр ч үгүй тийм эрх зүйн орчинтой бид явж ирсэн.

Төрийн өмчийн бэлчээр дээр хувийн өмчтэй мал аж ахуй эрхлэгч нар харилцан уялдаа нь хангагдахгүй байгаагаас холбогдож энэ бэлчээрийн доройтлын асуудал яригдаад байна.

Монгол Улсын нийт бэлчээрийн даацаар нь тодорхойлбол 86 сая хонин толгойтой тэнцэх тооны мал багтах чадамжтай гэж мэргэжлийн байгууллагууд судлан тогтоосон.

2022 оны эцсээр 120.7 сая хонин толгой байна.

1980-аад оны үед хүн амын хүнсний хэрэгцээ болон дотоодын мах боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эдээр тогтвортой хангах, мөн гадаадад мал, мах гаргах арга хэмжээг төлөвлөхдөө 10 жилийн судалгааг бүрэн тооцож үндэслэн бэлчээрийн даацыг зун, намартаа 87.4 сая хонин толгой, өвөл, хавартаа 49.9 сая хонин толгойтой байхаар тооцдог байсан байна.

Монгол орны бэлчээрийн төлөв байдлыг үндэсний тайланд дурдсанаар манай улсын нийт бэлчээрийн 65 хувьд ургамлын бүтэц, бүрэлдэхүүн харилцан адилгүй түвшинд өөрчлөгдөж, үүний 13 хувь нь цөлжсөн, 29 хувь нь хүчтэй доройтсон. Гэхдээ бэлчээр ашиглалтын ачааллыг өнөөгийн горимыг цаг алдалгүй өөрчилж, даацад нь нийцүүлж ашиглавал доройтсон нийт бэлчээрийн 80 гаруй хувь нь байгалийн аясаараа тодорхой хугацааны дотор эргэн сэргэх боломжтой гэсэн ийм дүгнэлт гарсан байна.

Иймд энэ боломжийг алдахгүйн тулд бэлчээрийн эрх зүйн зохицуулалтыг.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ж.Батжаргал гишүүний микрофоныг дахиад сунгая.

Ж.Батжаргал: Шаардлагатай түвшинд нь нэн яаралтай бүрдүүлэх явдал тулгамдаж байгаа тул бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, сэргээн сайжруулахтай холбогдох харилцааны зохицуулалтыг Газрын тухай хуульд шинээр нэмэлт, өөрчлөлт оруулж хуульчлах эрх зүйн энэ өөрчлөлтийг зайлшгүй хийх нийгэм, эдийн засгийн болоод байгаль орчны шаардлага, хэрэгцээ гарч байна.

Уур амьсгал, байгаль экологийн өөрчлөлт, ган, зудын эрчим, давтамж, хамрах хүрээ, хөрсний элэгдэл, бэлчээрийн талхлагдал, цөлжилт, шар шороон шуурга гэх мэт элдэв үзэгдэл, аюул гамшиг тохиолдож дөрвөн цагийн улиралд дураараа нүүдэллэх нутагтай гэж шүлэглэдэг байсан маань зөвхөн түүх болон үлдэж, талын Монгол бэлчээрийн нэлээн их эмгэнэлтэй байдалд хүрэх нөхцөл байдал үүслээ.

Байнгын хорооны хуралд танилцуулах хуулийн энэхүү төслийн талаар иргэдийн саналыг сонсох зорилгоор нийт орон даяар хэлэлцүүлгийг хийх ажлыг хууль санаачлагчдын зүгээс 5 бүсэд зохион байгуулж, малчид, мал бүхий иргэд, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид, орон нутгийн газрын болон бэлчээрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, аймаг, сум, багийн Засаг дарга нарыг хамруулан мянга гаруй хүнээс санал авлаа.

Хэлэлцүүлгийн үед явуулсан санал асуулгын дүнгээс үзвэл нийт оролцогчдын 97.7 хувь нь бэлчээрийн

талхлалт, доройтол байгаатай санал бүрэн нийлсэн байна.

Бэлчээрийн харилцааны эрх зүйн өнөөгийн орчныг өөрчлөх шаардлага байна уу гэсэн асуултад оролцогчдын 90.6 хувь нь заавал өөрчлөх нь зүйтэй гэжээ.

Бэлчээр ашиглалтын хэлбэрийн хувьд нийт оролцогчдын 46 хувь нь гэрээгээр ашиглах нь зөв гэсэн бол 27 хувь нь малын тоо толгойн албан татварын зохицуулалт цаашдаа чухал арга хэмжээ болно гэж үзэж байгаагаар илэрхийлсэн байна.

Бэлчээр ашиглах, хамгаалах уламжлал, сайн туршлага, орчин үеийн технологийн хяналтын болон үнэлгээний системд суурилан бэлчээр ашиглагчдаа өөрсдийн амьжиргааны орлогод нөөцтэй өөриймсөг хандах, зүй зохистой ашиглах, хамгаалах, хариуцлагажуулах зохицуулалтыг эрх зүйн хүрээнд бүрдүүлэх хэрэгтэй байна.

Манай улсын эдийн засгийн тулгуур салбарын нэг болох мал аж ахуйг үндэсний үнэт зүйлс, хөгжлийн алсын хараа, чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдал, дотоодын боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, экспортыг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх суурь үндэс нь бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, сэргээн сайжруулах харилцааг тогтвортой, үр өгөөжтэй болгох асуудлыг үзэл баримтлалд нь тусгаж, төрийн бодлого, нийтийн эрх ашиг, хүрээлэн буй орчны экологийн тэнцвэрт байдал, байгаль, амьтанд ээлтэй байх, өнөө ба ирээдүйн хөгжлийн эрэлт, чиг хандлагын уялдааг ханган зохицуулах зорилгоор Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэхүү хуулийн төслийг санаачлан боловсруулсан болно.

Энэ хуулийн төсөл нь 4 зүйлтэй бөгөөд хуульд хэрэглэгдэх нэр томъёог нэмж, бэлчээрийн ангиллыг шинэчлэн тогтоож, зохистой ашиглах, хамгаалах, сайжруулах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, эдгээр харилцаанд оролцогч талуудын эрх, үүргийг нарийвчлан тодорхойлох, тогтоох харилцааг зохицуулахаар тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дагаврууд гарна гэж үзэж байна.

1. Монгол орны бэлчээрийн мал аж ахуй эрхлэх өвөрмөц онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, зан заншилд суурилсан оролцогч талуудын эрх үүрэг хариуцлагыг нарийвчлан зохицуулсан эрх зүйн орчин бүрдэнэ.

2. Бэлчээрийг нийтээр хяналт зохицуулалтгүй ашигладаг, бэлчээрийг талхалдаг, доройтуулдаг, цөлжихөд хүргэсний төлөө хариуцлага хүлээлгэдэггүй явж ирсэн байдлыг халж бэлчээрт өөриймсөг хандаж даацад нийцүүлсэн хувиар сэлгээтэйгээр зохистой ашиглах, малын тоо толгойг өсгөх бус харин ашиг шим, чанарыг нь эрхэмлэхэд хөрөнгө хүч зарж, хамгаалах сэтгэлгээ төлөвшин эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бүрдэнэ.

3. Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх арга хэмжээг зохион байгуулалттайгаар хэрэгжүүлж, бэлчээрийн талхлалт, доройтол цөлжилтийг бууруулахад үр дүн авчирна.

4. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг урт хугацаанд тогтвортой эрхлэх, хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахад оруулах хувь нэмэр нэмэгдэнэ.

Малчид, хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох,

эрсдэл даах чадавхыг бэхжүүлэхэд эрх зүйн чухал зохицуулалт болно гэж үзэж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан болно.

Хуралдаанд танилцуулж буй хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Малын генетик нөөцийн тухай, Малын тоо толгойн албан татварын тухай, Төсвийн тухай, Зөрчлийн тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулахаар дагалдах хуулийн төслийг тус тус боловсруулж хамт хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн.

Иймд Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн танилцуулгыг хийж дууслаа.

Ж.Батжаргал гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан ирсэн ажлын хэсгийг танилцуулъя.

Б.Эрдэнэбаатар Монгол Улсын зөвлөх мал зүйч, хөдөө аж ахуйн бодлого судлаач, доктор, Д.Гүрбазар Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал ахуй, биотехнологийн сургуулийн захирал, доктор, Г.Сувдаа Хөгжлийн бодлого судлаач, Монгол Улсын зөвлөх, мал зүйч, доктор, Д.Булгамаа Бэлчээр ашиглагчдын холбооны Бэлчээрийн ургамал судлаач, доктор, М.Сувд Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, доктор, Ц.Энх-Амгалан хөдөө аж ахуйн

эдийн засагч, доктор, У.Будбаатар Бэлчээрийн экологи судлаач, магистр, Р.Болормаа Улсын Их Хурлын Тамгын газрын Зөвлөхүүдийн зөвлөх, Л.Лхагвасүрэн Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын зөвлөх.

Өргөн барьсан хуулийн танилцуулгатай холбоотойгоор асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ц.Туваан, Н.Ганибал, О.Цогтгэрэл гишүүнээр тасаллаа

Ц.Туваан гишүүний микрофоныг өгье.

Ц.Туваан: Маш чухал хууль орж ирж байгаа.

Бэлчээрийн тухай хууль гээд хууль яригддаг. Тэгээд улс төрчдийн хувьд бүр халуун сэдэв болчихсон. Гар халуун юм барих гэж байгаа юм шиг зугтаадаг асуудал болчихсон.

Одоо тэгэхээр бид хэдий болтол үүнээс зугтааж явах вэ. Одоо бэлчээрийн тухай хуулиас буруу шийдвэр гаргачихвал асуудал болно гэж тойрч зугтсаар байгаад энэ асуудлаа бид хэд хаячихсан.

Одоо бид үүнийг шийдэхгүй бол Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын хэмжээнд хүрэх асуудал болоод хувирчихсан.

Тэгэхээр энэ дээр бас нэг гаргалгаа гарах үүднээс Газрын тухай хуулийг санаачлаад нэмэлт, өөрчлөлт оруулахаар орж ирж байгааг 100 хувь дэмжиж байгаа. Одоо цаг нь болсон.

Бид бэлчээрийн асуудал ярихаар ганцхан хөдөө орон нутагт амьдарч байгаа малчдын асуудал юм шиг хандаж ирсээр байгаад өдийг хүрчихлээ.

Энэ бол одоо ерөөсөө ганцхан малчдын асуудал биш болсон. Сум, аймаг дээр амьдарч байгаа төв суурин газрын, тэгээд бүр цаашилбал Улаанбаатар хотын, тэгээд Монгол Улсын асуудал болсон учраас одоо хэдүүлээ энэ дээр нухацтай хандаж энэ асуудлыг явуулах ёстой гэдэг утгаараа дэмжиж байгаа.

Тэр бэлчээрийг ашиглаж байгаа хүн бол мэдээж малчин. Тэгээд бэлчээрийг малчид малаа өсгөж талхалж байна энэ тэр гээд ганцхан малчид руу буруугаа чихээд байдаг асуудал байдаг.

Миний хувьд энэ асуудлыг малчид яг амьжиргаагаа хөөж, өөрийнхөө орлогыг олох үүднээс энэ аж ахуйг эрхэлж байгаа.

Тэгэхээр энэ хүмүүс чинь өөрсдөө өрхийнхөө хэрэгцээг хангахын тулд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ л зарж байгаа шүү дээ. Махаа борлуулж байгаа. Ноос, арьс, шир, ноолуураа борлуулж байгаа.

Тэгэхээр энэ түүхий эдүүд нь ямар ч үнэ цэнгүй болсон. Хамгийн үнэтэй зардаг ноолуур гэхэд л өнөөдөр 120-иос 130 мянган хооронд энэ хавар борлуулсан. Энэ ам.долларт шилжүүлэх юм бол 40 хүрэхгүй доллар л байх жишээтэй.

Тэгэхээр энэ асуудлыг төр хийхгүй байгаа юм.

Энэ арьс ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах асуудал дээр маш хойрго, удаан ханддаг. Хөрөнгө оруулалт тавьж өгдөггүй. Дээрээс нь гадаад худалдаа эрхлэх. Өөрөөр хэлбэл энэ бүтээсэн бүтээгдэхүүнүүдийг гадагшаа зарах үйл ажиллагаа, ложистик, энэ хууль эрх зүйг нь ерөөсөө хийж өгдөггүй.

Тэгээд л буруу байвал малчид.

Тэр хүмүүс 100 мал борлуулаад өрхийн жилийн хэрэгцээгээ хангадаг байсан бол өнөөдөр тийм боломжгүй болсон.

20 мянгаар мах зарагдлаа гээд л энэ хаваржин шуугилаа. 20 мянгаар махаа зарсан малчин нэг ч байхгүй.

Ер нь зарсан нь ч буруудаад байх юм байхгүй.

Тэгэхээр иймэрхүү байдлаар хандаж байгаа.

Тэгэхээр одоо нөгөө тал төр, Улсын Их Хурал, Засгийн газар ажлаа хийх цаг нь болсон гэдгийг би энд хэлмээр байгаа юм.

Дээрээс нь бэлчээр маань одоо 30 хувь нь цөлжилтийн байдал руу орсон, талхлагдаж байгаа энэ тэр гээд ярьсан. Яг үнэндээ бол энэ хаврын улаан шороон шуурга энэ тэр бол ерөөсөө тоогоо алдсан шүү дээ.

Түүрэн энэ тэр бол тоогоо алдсан. Одоо энэ жил зуншлага гандуу байна. Энэ тэнд алаг цоог зун болж байна. Ирэх өвөл бүр хүндэрнэ. Нэг жоохон байгаа газар дээрээ овоорно.

Байгалийн хадлан хаддаг гол бүс нутгуудад зүүн талд ган болж байна. Өнөөдөр халуун зунаар Дорнод аймгийн Матад сумд түймэр гараад байж байна.

Тэгэхээр энэ өвөл хүндэрнэ. Тэгэхээр одоо бид хэд үүнээс ухралгүй энэ асуудлуудаа барьж аваад шийдэх цаг нь болчихсон гэж бодож байгаа.

Ажлын хэсгээс нэг зүйл дээр. Энэ төрийн зохицуулалт дээр та хэд ер нь нэг, хоёр, гурав гээд хийвэл ямар асуудлыг

хамгийн түрүүнд ач холбогдлоороо эрэмбэлж хийх ажил гэж үзэж байгаа вэ?

Мэдээж та хэд санал бодлоо солилцсон байгаа. Үүнийг нэг сонсчихмоор байна.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг. Хэдэн номер вэ? 6 номерын микрофоныг нээ.

Г.Сувдаа: Ажлын хэсгийн гишүүн, судлаач Г.Сувдаа.

Тэгэхээр сая Ц.Туваан гишүүний хэлж байгаа нөхцөл байдал яах аргагүй бид цаашид ямар гаргалгаа хийж байж энэ нөхцөл байдлаас гарах юм бэ гэдэг асуудал дээр зайлшгүй очиж байгаа.

Тэгэхээр Монгол Улсын нийт мал сүргийн маань 45 орчим хувь нь эх мал байгаа.

Судлаачдын авч үзэж байгаагаар бодит байдлаар 51 сая мал байхад зохистой гэж үзэж байгаа. Одоогийн 71 саяын хооронд 20 сая орчим малыг бид яах аргагүй эргэлтэд оруулах шаардлагатай байгаа юм.

Тэгэхээр төрийн зүгээс нэгдүгээрт энэ экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлийг, тухайлбал мах дээр явуулахдаа нэгдүгээрт тэр малчин хүний экспортыг явуулах чиг баримжааны сонирхлын хөшүүргийг нь тэр чиглэл рүү нь хандуулах шаардлагатай байна гэж үзэж байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, яах аргагүй эрх зүйн хүрээнд нь бид энэ үйлдвэрлэл явуулж байгаа газрын харилцааных нь асуудлыг зохицуулалт хийж өгөхгүйгээр цаашаага энэ үйлдвэрлэлийг тогтворжин авч явах асуудал нь боломжгүй байгаа.

Гуравдугаарт, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнийн асуудал дээр яах аргагүй зах зээлийн харилцаа руу нь шилжүүлж өгөх энэ харилцаан дээр үйлдвэрүүд, цехүүд орон нутагт авах энэ тогтолцооны асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байгаа.

Энэ гурван асуудал дээр эхний поинт өгч байгаа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Н.Ганибал гишүүн. Н.Ганибал гишүүний микрофоныг нээ.

Н.Ганибал: Энэ хуулийн санаачлагчдын нэг л дээ.

Өнөөдөр би ярих гээд байгаа гол асуудал хууль маань жоохон мөлгөр байгаа. Тодорхойгүй заалтууд маш ихтэй байгаа юм.

Яагаад гэхээрээ бид ярилцаад тодорхой заалтуудыг оруулж ирэхээр эргээд нөгөө улс төрийнхөө галыг даахгүй ч гэдэг юм уу, малчдад бэлчээрийг нь хувьчлах гээд байна.

Хашаа татах гээд байна. Олон л асуудлуудыг ярьдаг шүү дээ. Бараг Монгол Улсыг худалдах гээд байна энэ тэр гээд.

Ийм байдлаасаа айгаад байдаг байхгүй юу. Бид. Одоо ч гэсэн айлж л байна л даа. Гэхдээ хиймээр байна. Хийхгүй бол болохгүй болчихоод байгаа байхгүй юу.

Одоо би хэд хэдэн асуудлыг жоохон чангалж өгөхгүй бол ер нь бас болохгүй.

Би өнөөдөр бид Монгол Улсын нийт бэлчээрийн маань даац хэд дахин илүү өссөн гэдгийг бүгдээрээ нүдээрээ харж байгаа. Манай малчид бүгд ойлгож

байгаа. Одоо тэд яах вэ гэдгээ малаа өсгөөд л тэгээд л хараад байгаа байхгүй юу.

Нөгөө экспортын махны үнэ өслөө гэнгүүт хотынхон хашхирсаар байгаад л экспортыг нь хориулдаг жишиг бид 30 жил явлаа.

Тэгээд түүнээсээ ямар ч байсан сална гэдгээ.

Харин манай Х.Болорчулуун сайдын нэг сайн тал махны экспортыг хэзээ ч зогсоохгүй гэдгээ амлаад байгаа.

Энэ бол маш зөв бодлого оо гэдэг дээр баярлаж явдгаа хэлчихье.

Одоо харин цаашид үүнийгээ бас нэг жоохон. Бид махны экспорт хийнэ гэхээр малчдаа бас хүлээгээд байдаг болсон. Манай малчид хэдэн хонь зарах бол, хэдэн үхэр зарах бол. Тэгэнгүүт нь тэр нь өөрөө бас тодорхойгүй. Тэр жилийн байдлаасаа хамаардаг.

Тэгэхээр бид одоо яг энэ бодит шинжлэх ухаан руугаа оруулна гэвэл Монгол Улсын нийт бэлчээрийн даац нь хэд юм, тухайн малчинд ноогдож байгаа бэлчээрийн хэмжээ нь хэд юм, тэндээ хэдэн мал маллах боломжтой юм гэдэг бүх тооцооллууд байгаа.

Үүнийг нь бид хуульчилж өгөх зайлшгүй шаардлага гараад байгаа юм.

Магадгүй мянгат малчнууд маань бэлчээрээсээ илүү олон малтай л байгаа байх. Энэ хүмүүс маань бас жоохон дургүйцэх магадлалтай.

Гэхдээ хэрвээ бэлчээртэй цөөхөн малтай малчин байвал тэр хүн түрээслүүлдэг юм уу, маллуулдаг юм уу ингээд эдийн засгийн зөв зохистой

байдалд нь оруулах бид нарын үндсэн үүрэг үлдчихээд байгаа байхгүй юу.

Бид нарын энэ хууль тийм юм руу л явах ёстой.

Дараа нь ингээд энэ дээр ингээд заачихсан байгаа юм л даа. Бусдын өвөлжөө, хаваржаа руу мал оруулахгүй, тэгээд өвөлжөө, хаваржааны бэлчээрт зун, намрын улиралд мал оруулахгүй хамгаалах, бэлчээрийг доройтуулахгүй байх, хортон мэргэжилтэй тэмцэх арга хэмжээ авах.

Яаж хамгаалах вэ? Тодорхойгүй шүү дээ. Тийм үү? Ийм заалт заагаад өгчихсөн байхад бид одоо юу гэдэг юм хашаа барьж болох юм уу, болохгүй юм уу? Хашна гэвэл ямар байх юм.

Хэрвээ айлын өвөлжөө, хаваржаа руу мал оруулсан бол нөгөө оруулсан эзэнд нь ямар зөрчлийн болон хариуцлага үүрүүлэх юм гээд ингээд юмыг нь жоохон тодорхой болгохгүй ерөнхий заалтуудыг бид оруулаад оруулаад өнөөдрийн бид нарын гаргах хууль маань үр дүнд хүрэхгүй.

Тэгэхээр бодит амьдрал дээр байгаа бүх асуудлууд малчид өөрсдөө ярьж байна. Бид ингэж ингэж. Одоо тэгээд л хамгийн хүнд хэсэг нь ган, зудтай үед бид яах юм? Одоо тэр дундын отрын бүсүүдийг заавал малчдаасаа очиж гуйж авах юм уу, нэг эсвэл ингээд Монгол Улсын хэмжээнд тэрийг зураглалыг нь гаргаад үүнийг бол ингээд Их Хурлаар байх юм уу бүр ингээд шийдэж өгмөөр байгаа байхгүй юу.

Одоогийн мөрдөж байгаа хууль дээр ямар байдаг вэ гэхээр аймаг дундын отрын бүс, сум дундын отрын бүсийг малчдаас санал аваад санал нь хэдэн хувь нь үүнийг зөвшөөрсөн тохиолдолд Их

Хурлаар оруулж баталдаг байгаа. Тийм үү?

Энэ дээр бид арай өөр байдлаар нэг асуудалд хандахгүй бол энэ ажил чинь өөрөө уначихсан байгаа.

Тэгэхээр энэ болгоныг маш том зураглалаар нь зөв харж зоригтой шийдэхгүй бол олон ерөнхий заалт бид нарын өнөөдрийн шийдэл биш гэдгийг л хэлэх гээд байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Хариулт. Ж.Батжаргал гишүүн хариулъя.

Ж.Батжаргал: Тэгэхээр нэг ийм л зүйл байна л даа.

Бид хэд бэлчээрийн мал аж ахуйтай улс орон. Тийм учраас бэлчээрийн мал аж ахуй, өвс тэжээлийнхээ хэрэгцээг бэлчээрээсээ олж иддэг.

Тэгэхээр мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангана гэвэл бэлчээрийн зөв менежментийн тухай асуудал байгаа.

Байгалийн даац чадамжид амьдрал ахуйгаа нийцүүлэх тухай л асуудал байгаа.

Ерөөсөө ганц үнэн юм энэ л байгаа.

Тийм учраас Газрын тухай хуульд бэлчээрийн газартай холбоотой харилцааг нь зөв зохицуулах үүднээс энэ хуулийн төслийг бид боловсруулсан. Энэ хууль батлагдсанаар бүх зүйл шийдэгдэхгүй.

Үүнийг дагуулж шийдэх юмнууд байгаа. Төрийн бодлого, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн асуудал, тэгээд

дагасан хууль тогтоомжуудаараа бүтэн зохицуулна.

Тийм учраас хөдөө аж ахуйн салбарын ашиг шимт түүхий эдүүдийн боловсруулалтын түвшин, үнэ өртгийн асуудал, аж ахуй, зохион байгуулалт, дэмжлэгийн асуудал энэ тэр гээд олон зүйлийг бид ярих ёстой. Давын өмнө дагасан хуулиудаараа зохицуулж байгаа.

Дэндүү мөлгөр байна гэж.

Ерөөсөө өнөөдөр газрын тухай харилцааг бид тухайн нэгжүүдийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, тухайн жилийн төлөвлөгөөгөөр зохицуулж явж байгаа.

Энэ төлөвлөгөөнд нь бэлчээрийн газрынхаа төлөв байдлыг үнэлээд ямар зохицуулалтын арга хэмжээ авах юм бэ гэдэг юмаа төлөвлө л гэж байгаа.

Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө нэг жил. Нөгөөдөх нь 16 жилийн баримт бичиг байгаа.

Тийм учраас нэлээн алсыг харсан түвшиндээ боловсруулж хийнэ.

Бэлчээрийн газрын зохистой ашиглалтын асуудлыг үндсэн ашиглагч болсон малчдыг хамтын хариуцлагын тогтолцоогоор нь дамжуулж хангуулна гэдэг ийм л том концепц явж байгаа.

Үүгээр дамжиж бүх асуудал шийдэгдэнэ гэж ингэж харж байна.

Нөгөө тал Зөрчлийн тухай хууль үүнийг дагаад ороод ирж байгаа. Тодорхой хэм хэмжээ, хязгаарлалтууд зөрчвөл тэр хуулиараа холбогдох арга хэмжээ юмнууд нь авагдана.

Бид ерөөсөө угаасаа энэ бэлчээр ашиглалтын хуваарьтай улсууд шүү дээ. Дан дамаа энэ өвөл, хаврын хатуу цаг үед ашигладаг бэлчээрийн ургамлын үр тогтолт, хөвөлтөөс нь өмнө чөлөөлж өгдөг. Тэгээд үндсэндээ хүнд цаг үеэ эхлэхээс өмнө орж иддэггүй л байсан ийм л уламжлалтай.

Үндсэндээ 5 сарын 01-нээс өмнө энэ нутгаа чөлөөлөөд 11 сарын 15 хүртэл ашигладаггүй ийм хуваарьтай явсан ийм л зүйл.

Энэ ерөнхий зарчим юмнуудыг нь энэ хуулийн ерөнхий үзэл санаагаар зохицогдоно гэж л харж оруулаад байгаа л зүйл шүү дээ.

Тийм учраас би энэ талаас сан энэ зохицуулалт юмнууд нь бүрэн явчихна гэж ингэж ойлгож байгаа.

Нөгөө талд энэ хуулийг санаачлах хамгийн том харагдсан зүйл бол бэлчээр нутгийн 65 хувь нь ямарваа нэгэн хэлбэрээр доройтчихоод байгаа юм.

Үүний 80 хувь нь тов тодорхой зөв менежмент явуулах юм бол байгалийнхаа жамаар сэргэх бололцоо нь байна шүү гэдгийг мэргэжлийн байгууллага дүгнэчихсэн учраас одоо ёстой өөрийн чинь хэлдгээр халгаад байлгүй барьж аваад, тэгээд энэ цөлжилт юмнуудынхаа хурдцыг бууруулаад, тэгээд цааш нь сайжруулалтынхаа юмнуудыг зөв зохистой хийгээд. Ингэснээрээ тогтвортой мал аж ахуйн үйлдвэрлэлийн тухай асуудлаа авч үлдэх юм л гэж ингэж л харж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Тодруулья. Н.Ганибал гишүүн.

Н.Ганибал: Хоёр л асуудал байгаа юм.

Нэг нь хамгаална, нөгөөдөх нь бид бий болгоно, ургуулна.

Одоо бид нарт малын тэжээлийг яаж бий болгох вэ гэдэг асуудал нь энэ хуулиараа бас давхар нэмж оруулж ирэх зайлшгүй шаардлагатай.

Ногоон тэжээлээ яаж тарих юм, тэндээ яаж малаа үлдэгдэл дээр нь өвөлжөө өвөл тэжээж болох юм гээд.

Тэгэхээр энэ хоёр л асуудал байгаа байхгүй юу.

Нэг нь хамгаалъя. Хоёр дахь нь ургуулья.

Тэгээд ургуулаад бий болгочих юм бол бид магадгүй мэдээж идэх хоол хэдий хэмжээтэй байна тэр хэмжээндээ бид бас мал аж ахуйгаа эргээд өсгөчхөж болно.

Үржлийнх нь тэр илүү таваарлаг болох энэ боломжууд нь бүрдэнэ л дээ.

Тэгэхээр энэ хоёрыгоо бас хослуулан цаашид авч явах асуудал дээр хэдүүлээ одоо энэ ажлын хэсгүүд дээр маш онцгойлон ярих нь зөв байх гэсэн саналтай байна.

Ж.Бат-Эрдэнэ: Х.Болорчулуун гишүүн.

Х.Болорчулуун: Монгол Улс энэ 100 жилд бэлчээрийн хууль гэж байхгүй ирсэн.

Социализмын үед ч тэр, одоо ч тэр.

Ер нь Монголд хамаагүй хатуу хуульчилж болохгүй зүйл бол бэлчээр гэж би боддог юм.

Монголчууд дураараа нүүдлийн мал аж ахуй эрхэлж, өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа гэж нүүж явдаггүй.

Яг үнэндээ Монгол Улсын цаг уур, уур амьсгал Төв Азийн өндөрлөг бүсэд хуурай цаг агаартай, жилийн дундаж хур тунадас нь 250-иас 300 гаруй миллиметр байдаг. Говьд 200 ч хүрэхгүй. 100 гаруй байна.

Ийм учраас хангалттай зарим хур тунадас ордог оронтой адилхан ногоо ургадаггүй гэж хэлж болно.

Ялангуяа дэлхийн дулаарлаас болж 70, 80-аад оны 90 он хүртэлх тэр сайхан зуншлагатай байдаг үе байхгүй болсон.

Тийм ч учраас хуучин бүр аймаг дамжиж хэзээ ч нүүдэггүй байсан. Одоо аймаг дамжиж нүүдэг болсон нь ийм учиртай.

Энэ оруулж ирж байгаа бэлчээрийн асуудлыг хөндсөн Газрын хуульд нэмэлт оруулах асуудал их ерөнхий байна. Үнэхээр ерөнхий байна.

Яг амьдрал дээр бэлчээр зохицуулалтаар юу харагдаж байна гэхээр тэр бэлчээрийн гэрээ ашиглаж хийнэ гэхээсээ илүү говь, талын нутагт худагт цэгийн зайг яг хуульчилж өгмөөр байна.

Энэ бол жишээлбэл говь, тал нутагт 4 километрээс доошгүй худаг цэг байна гэж оруулах жишээтэй.

Хангайд арай бага. 1 километрийн татуу байж болно. Энэ байхгүйгээс маш их маргаан гарч байна.

Нөгөө мал дээр, уламжлал дээр амьдарч байгаагүй хүмүүс аймаг, сумдаас малчин болж гарахдаа айлын хажууд 2

километрийн зайтай худаг ухчихдаг. Километр газрын зайтай худаг ухчихдаг.

Ингээд л тэр хавийн бэлчээрийг, аль алиныхаа бэлчээрийг байхгүй болгодог. Энэ л малчдын санаа зовоосон асуудал болж байгаа юм.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ бэлчээрийн асуудал нь сөхөгдөж байгаа. Энэ л амин сүнс шүү.

Түүнээс биш хуучин социализмын үед ч гэрээгээр яагаад, хуваарьтайгаар ашиглуулна гэж дүрэм, журам гаргаад ч, хууль гараагүй ч гэсэн бараагүй юм. Үүнийг ажлын хэсэг анхаараач гэж хэлэх байна.

Хоёрдугаарт, сая Н.Ганибал гишүүний хэлдэг бид зөвхөн байгалийн тэр ургамлын байдлыг хараад малаа бэлчээгээд байх биш. Малчин өрх ялангуяа фермерийн аж ахуй хажуудаа газрын хуульд бас манай яамны санд явж байгаа л даа. 20 хүртэл га-г ногоон тэжээл барь тарьж ашиглаж болохоор зааж өгсөн байгаа. Энэ тэрийг оруулж байж арай энэ бэлчээртэй холбоотой юу чинь бас нэлээн амьд болно.

Түүнээс биш ийм байдлаар ийм мөлгөр хууль дагнаж оруулах дэмий л гэсэн бодолтой байна.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ.

Ж.Батжаргал гишүүн хариулья.

Ж.Батжаргал: Ямартай ч хуулийн төсөл боловсруулаад өргөн мэдүүлээ. Хэлэлцэх эсэх яригдаж байна.

Би бүх нийтээрээ дэмжчих нь зөв байх.

Хэлэлцүүлгийнхээ явцад тодорхой тодорхой заалтууд дээр томьёоллоо аваад, сайжруулаад явах бололцоо нь бидэнд бүрдэнэ гэж ингэж харж байгаа.

Тийм учраас энэ талаасаа асуудалдаа хандах ёстой.

Энэ худаг, ус цэгийн асуудлыг хөндвөл нэлээн ул суурьтай л ярих тухай асуудал байгаад байгаа.

Усны хайгуул судалгааны ажлууд орхигдсонтой холбогдуулаад худаг, ус цэг гаргаж байгаа байгууллагууд эрсдэлгүй байдлаа хангах үүднээс өмнөх худгуудыг түшсэн байдлаар худаг явц, цэгүүд гаргаад байгаа үйл явц үүнтэй холбоотой.

Хоёрдугаарт, төрийн өмчийн газар бэлчээр дээр хувийн өмчийн худаг гаргах үйл явцыг бид дэмжээд яваад байгаатай холбоотой зүйл. Малчин өрх бүр өөрөө худагтай, зардлаа хариуцаад худаг гаргаад байгаа явдалтай энэ асуудал холбоотой.

Энэ мэтчилнээр бидэнд судалж зөв зохицуулалт хийх тухай асуудал.

Тийм ч учраас бид энэ хуульд ер нь гол усаараа бэлчээр ашиглалтын бүлэг гэж байх юм. Тэр бүлэг хамтдаа асуудлаа ярьж шийдлээ гаргадаг байх ёстой юм гэдэг энэ үзэл санаан дээр хийсэн.

Тийм учраас би цаашид энэ худаг, ус цэгийн асуудал энэ тэр бол заавал бүлэг дээр яригдаж байж асуудал яригдана. Нэг.

Хоёрдугаарт, худаг ус цэгийн ашиглалтын асуудал хүртэл үүнийгээ дагаж зөв хуваарь луугаа явах ийм бололцоо боломж нь бүрдэнэ гэж ингэж харж байгаа.

Тийм учраас энэ талаасаа харж асуудлаа шийдэх зүйлүүд байгаа.

Ногоон тэжээл тариалалтын асуудал. Үнэхээрийн уур амьсгалын өөрчлөлт бий болчихсонтой холбогдоод байгалийн хадлан бэлтгэлт жилээс жилд саарч байгаа.

Тэгвэл нөгөө талд нь бид таримал ургамлаар тэжээлийн нөөц бүрдүүлэлтийнхээ асуудлыг л шийдэх ёстой.

Тийм учраас энэ малчид өөрийн өвөлжөө, хаваржааныхаа хөлд тодорхой хэмжээний ногоон тэжээл тариад хурааж авдаг ийм бололцоог нь бүрдүүлж өгье.

Хоёрдугаарт, ерөөсөө тэр хуучин хөдөө аж ахуйн нэгдлийн үед газар тариалангийн ангилалд байсан ногоон тэжээл тарьж байсан талбайнууд дээрээ ангилалт юмнуудаа хийж ногоон тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэх замаар тэжээл үйлдвэрлэлийг өсгөх ийм л бололцоо боломжийг нь хангаж өгөх ёстой.

Газар тариалангийн бүс, эрчимжсэн мал аж ахуйн бүс хоёр хоёулаа давхцаж байгаа учраас тариалангийн бүс нутагт тодорхой тариалангийн талбайн ашиглалтыг сайжруулах хэлбэрээр ногоон тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэх ийм бололцоо боломжуудыг нь хангах, энэ хоёр салбарыг хооронд нь хослуулж нэг нь нэгнийгээ тэтгэж хөгжих боломжийг нь бүрдүүлэх л ийм л бодлого зохицуулалт байгаа л гэж ингэж л хараад байгаа шүү дээ.

Тэгээд хэлэлцүүлгийн явцад илүү нарийсгаж судалж тодорхой томьёолох зүйлүүд гарна байх гэж би ингэж бодож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд хуулийн танилцуулгатай холбоотой асуулт асууж дууслаа.

Санал хэлэх гишүүд байна уу?

Хуулийн танилцуулгатай холбоотойгоор санал хэлэх гишүүд алга байна.

Ингээд гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. Санал хураалт явагдана. Тийм үү.

Өргөн барьсан хуулийн үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал 57.1 хувиар дэмжигдлээ.

Ингээд чуулганы хуралдаанд төслийг үзэл баримтлалын хүрээнд чуулганы хуралдаанд танилцуулж, Байнгын хороогоор хэлэлцсэн эсэх талаар танилцуулах танилцуулгыг Г.Мөнхцэцэг гишүүн танилцуулах уу? Г.Мөнхцэцэг гишүүн танилцуулъя.

Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудал энэ чинь гуравдугаар асуудал байж байгаа. Тийм ээ.

Нэмэлтээр нэг асуудал орж ирсэн байгаа.

Ингээд дараагийн асуудлыг хэлэлцье.

Дөрөв. “Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын хуулийн 1995 оны 26 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн 2021.05.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

“Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын хуулийн 1995 оны 26 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Анхны хэлэлцүүлэг. Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн 2021 оны 5 сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төсөл байна.

Ингээд тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Улсын Их Хурал Чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

Тогтоолын 1 дүгээр заалт дээр тогтоолын төсөлтэй танилцуулна.

Улсын Их Хурлын тогтоол. Тогтоолын танилцуулаадахъя.

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын 1995 оны 5

дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар тогтоолын 3 дахь заалтад 4.Архангай аймгийн Жаргалант, Тариат, Өндөр-Улаан сумын нутаг дахь Далтын нуруу, Шарагчны голын ай сав гэж нэмсүгэй.

2.Байгалийн нөөцийн газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авч байгаа газар нутгийн хуулийн заагийг тогтоохыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюунэрдэнэ/-т даалгасугай гэсэн тогтоолын төсөл байна.

Энэ хууль дээр гарсан ажлын хэсгийн ахлагч Ж.Батжаргал гишүүн тайлбар хэлэх үү.

Ж.Батжаргал гишүүний микрофоныг нээе.

Ж.Батжаргал: Тэгэхээр юу юм. Энэ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн харилцаагаараа Тусгай хамгаалалттай газар нутгийг 4 ангиллаар аваад байгаа юм.

Энэ байгалийн нөөц газрын ангиллаар авч байгаа тохиолдолд хилийн зааг талбайн хэмжээг нь Засгийн газар тогтоохоор ийм хуулийн зохицуулалттай юм билээ.

Тийм учраас манай ажлын хэсэг ерөнхий дэвсгэр нутгийнх нь хэмжээнд судалж үзээд энэ бол ерөнхийдөө авч болох ёстой ийм газар юм байна. Энэ дээр манайх дүгнэлт гаргах шаардлагагүй юм байна. Угаасаа бид Улсын Их Хурлын тэр тогтоолын төсөл дээр нэмэлт нэр заагаад орууллаа.

Тэгээд тэр доторх бүхий л газар нутаг дээрээ тодорхой судалгаагаа мэргэжлийн байгууллагууд нь хийгээд, яаж хилийнхээ цэсийг тогтоох барих асуудал нь Засгийн газрын бүрэн эрх байгаа учраас бид эндээс янз бүрийн

байдлаар дүгнэлт оруулах илүүц юм байна.

Тийм учраас тэр бүрэн эрхийнх нь хүрээнд Засгийн газарт нь чиглэлээ өгөх нь зөв юм байна гээд ерөөсөө улсын тусгай хамгаалалтад авч байгаа газар нутгийн тэр тогтоол дээр шинээр нэрийг нь зааж өгч оруулаад тэр хилийнхээ цэс, талбайн хэмжээгээ тогтоох асуудлыг өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд Засгийн газар нь шийд гэдэг чиглэлээ 2 дугаар заалтаараа өгөх нь зөв юм байна гэж ингэж тогтсон зүйл шүү гэдгийг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Сая би танилцуулсан. Зүйл бүр бүрээр хэлэлцэнэ.

Ингээд тогтоолын 1 дүгээр заалт дээр асуулт, саналтай гишүүд байна уу? Г.Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа. Г.Мөнхцэцэг гишүүн.

Г.Мөнхцэцэг: Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлууд дээр санал хураалтад орж дэмжиж байгаа гэдгийгээ протоколд тэмдэглүүлчихье. Хурлын дарга аа.

Тэгээд Газрын тухай хуулийг мэдээж бас энэ хуулийг өргөн барилцсан гишүүний хувиар дэмжиж байгаа.

Энэ гарч байгаа тогтоолдоо, батлах гэж байгаа тогтоолтой холбоотойгоор бас хоёр, гурван санал хэлье гэж бодож байгаа юм.

Энэ тогтоолыг дэмжиж байгаа. Гарч байгааг нь дэмжиж байгаа.

Тэгээд өнгөрсөн жил манай Байнгын хорооноос яг энэ тусгай хамгаалалттай газар нутгууд дээр яг энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг Ж.Батжаргал гишүүнээр ахлуулаад ингээд ажилласан. Миний бие

бас говийн бүсийг хариуцаад ажилласан юм.

Тэгээд Байнгын хорооноос ингээд ажлын хэсэг гараад ажилладаг. Тэгээд ямар нэгэн байдлаар ерөөсөө ингээд нөгөө ажлын хэсгийн үр дүн, ажилласны үр дүн ач холбогдол гэдэг юм ер нь аягүй их буураад байна. Бид энд ажиллаад өчнөөн жил өчнөөн километр зам туулаад л ингээд л яваад ирсэн.

Тэгээд яг үндсэндээ ямар ажлын үр дүн гаргасан гэдэг нь тодорхойгүй байгаад байдаг. Тэгвэл ингэж ажлын хэсэг гарч ажиллах хэрэгтэй ч юм уу, үгүй ч юм уу.

Тэгээд Байгаль орчны яам, Засгийн газар яагаад энэ тусгай хамгаалалттай газар нутгуудын тухай хуулийнхаа шинэчилсэн найруулга орж ирэхгүй зөвхөн тогтоол хэлбэрээр ингээд энэ юунуудыг аваад байгаа юм бэ гэдгийг би бас гайхаад байна.

Тэгэхээр энэ дээр манай байнгын хороо бас тодорхой хэмжээний санал санаачилга гаргаж ажилламаар байгаа юм.

Миний бие 7, 8 жил ярьж байна. Бараг энэ тусгай хамгаалалттай газар нутгуудын тухай асуудлыг авч хэлэлцээч гэдэг зүйлийг.

Одоо ингээд Сүхбаатар аймаг Алтан-Овоо, Говьсүмбэр аймаг Чойрын Богд, Дорноговь аймаг Ханбаянзүрх хайрхан, Өмнөговь аймаг Дэмчигийн хийд, Дундговь аймаг энэ Дэл хөнжлийн уул гээд энэ газар нутгуудыг тусгай хамгаалалтад авах, тусгай хамгаалалтынх нь зарим нэг үйл ажиллагааг нь жигдрүүлэх, ангиллыг нь ахиулах гээд энэ саналуудыг, судалгаануудыг олон жил хийсэн.

Тэгээд ерөөсөө Байгаль орчны яам энэ асуудлуудыг эрэмбэлээд оруулж ирдэггүй. Зөвхөн тогтоол хэлбэрээр оруулж ирээд нэг ийм хэсэгчилж батлаад байгааг би ерөөсөө ойлгохгүй байна.

Тэгэхээр энэ тусгай хамгаалалттай газар нутгуудын хуулийн шинэчилсэн найруулгыг яаралтай оруулж ирээч ээ. Энэ дээр Байнгын хороо санал санаачилга гаргаж ажиллаач ээ.

Бид нэг хэдэн хүн ингээд л ажлын хэсэг болоод л ажиллаад л ингээд л яваад ирдэг. Ямар нэгэн байдлаар ажлын хэсэг гарч ажилласнаас үр дүн гардаггүйгээр ингэж ажлын хэсэг ажиллаад яах юм бэ.

Тийм учраас энэ дээр анхаарч ажиллаач гэдгийг бас хэлмээр байгаа юм. Тэгээд тогтоолын төслийг дэмжиж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Г.Мөнхцэцэг гишүүн санал хэллээ.

Ер нь тогтоолын төсөлтэй холбоотойгоор ажлын хэсгийн гарсан дүгнэлт ажлын хэсэг гаргаад танилцуулчихсан юм байна. Тийм үү? Засагт өгсөн юм байна.

Тэгэхээр одоо Монгол Улсын Засгийн газар, Байгаль орчны яам тодорхой хэмжээний энэ дүгнэлт дээр үндэслээд хуульд өөрчлөлт оруулсан шинэчлэлүүд оруулж ирэх хэрэгтэй болчихоод байна шүү дээ. Тийм.

Тэгээд ямар ч байсан Байнгын хорооноос зохих салбарын яаманд энэ хуулийн төсөл дээр санал боловсруулж оруулж ирэх үүрэг даалгавар бас энэ хуралдаанаас өгч байна.

Ингээд тогтоолын 1 дүгээр заалтыг хэлэлцэж дууслаа. Тодорхой санал гараагүй байна.

Тогтоолын төслийн 2 дугаар заалт дээр санал хэлэх, асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Ингээд Г.Тэмүүлэн гишүүн горимын санал гаргаж байна.

Г.Тэмүүлэн: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.22-т заасны дагуу яг анхны хэлэлцүүлэг дээр нь ямар нэг зарчмын санал гараагүй бол горимын санал гаргаж нөгөө хуулийн төслийг анхны хэлэлцүүлгийг нь эцсийн хэлэлцүүлэгтээ эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргаж болно гэж заачихсан байгаа юм.

Тэгэхээр анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг гаргаж байна.

Тэгээд үүнийг дэмжиж өгөөч ээ л гэж хэлэх гэсэн юм.

Ж.Бат-Эрдэнэ: “Улсын тусгай хамгаалалтын газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын 1995

оны 26 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Горимын санал. Г.Тэмүүлэн гишүүн анхны хэлэлцүүлгээр баталъя гэсэн горимын саналыг оруулж ирж байна.

Горимын саналаар санал хураалт явуулъя. Дэмжих эсэх талаар. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал 71.4 хувиар дэмжигдлээ.

Нэгдсэн хуралдаанд анхны хэлэлцүүлгийг хэлэлцсэн эсэх санал, дүгнэлтийг Ц.Идэрбат гишүүн танилцуулах уу? Ц.Идэрбат гишүүн танилцуулъя.

Ингээд өнөөдрийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудал хэлэлцэж дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Хуралдаан 01 цаг 33 минут үргэлжилж, 12 цаг 00 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД